

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН
ГАРЫН АВЛАГА



Ашиглалтын
лицензийг
хэрхэн
олгодог вэ?



Энэ үйл явцад
иргэд хэрхэн
нөлөөлөх вэ?



Ашигт
малтмалын
хайгуул болон
ашиглалтын
үйл
ажиллагааг
зохицуулах
Монгол
улсын хууль
журмууд

ГАРЧИГ

Өмнөх үг	2
Талархал	3
Гарын авлагын зорилго	4

Нэгдүгээр бүлэг: Иргэдийн эрх, үүрэг	5
--	---

Хоёрдугаар бүлэг: Ашигт малтмалын лиценз олгох үйл явцад иргэдийг үр дүнтэйгээр татан оролцуулах арга зам	9
---	---

Гуравдугаар бүлэг: Хайгуулын лиценз олгох үйл явцад иргэдийг оролцуулах арга зам	15
Хайгуулын лиценз олгох журам	15
Хайгуулын лицензийн тухай нэмэлт мэдээлэл олж авах	20

Дөрөвдүгээр бүлэг: Ашиглалтын лиценз олгох үйл явцад иргэдийг оролцуулах арга зам	23
Ашиглалтын лиценз олгох журам	24
Ашиглалтын лиценз олгох үйл явц дахь иргэдийн оролцоо.	25
Ашиглалтын лицензийн талаарх нэмэлт мэдээлэл олж авах	27

Тавдугаар бүлэг: Эерэг үр дүнгийн төлөө ажиллах	31
Хавсралт 1 – Үйлчилгээний төлбөр	36
Хавсралт 2 – Холбогдох байгууллагуудын хаяг	37
Хавсралт 3 – Холбогдох хууль, тогтоомж	40

Өмнөх Үг

Дэлхийн эдийн засаг хурдацтай өргөжин тэлэхийн хэрээр компьютерээс авахуулаад автомашины үйлдвэрүүдэд хэрэглэгддэг түүхий эдийн хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байна. Хятад улстай хил залган оршдог, нүүрс, алт, зэс гэх мэт олон төрлийн ашигт малтмалаар баялаг Монгол орон нь гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татан, дэлхийн зах зээлийг түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүнээр хангах чухал нийлүүлэгч болох бололцоотой орон юм. Энэхүү бий болж буй хэрэгцээ шаардлагыг хангахад уул уурхай чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ.

Олон компани, хувь хүмүүс уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2006 онд Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний 17 хувийг уул уурхайн салбараас бүрдүүлсэн. 2007 оны байдлаар 69 сая га газрыг хамарсан талбайд (Монгол орны газар нутгийн 44 орчим хувь) үйл ажиллагаа явуулах 5800 гаруй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Монгол улсын төмөрлөгийн болон ашигт малтмалын баялаг нь улс үндэстний эдийн засгийн өсөлтөд урт удаан хугацаанд үр ашгаа өгөх боломжтой боловч уул уурхайн үйл ажиллагааг хяналтгүй явуулбал энэ боломжийг үгүй болгох болно. 1997 онд уул уурхайн салбарыг удирдан зохицуулахаар ашигт малтмалын тухай хуулийг баталсан нь чухал эргэлтийн үеийг бий болгосон

бөгөөд ингэснээр томоохон гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж чадсан юм. 2006 онд Ашигт малтмалын тухай хуулинд шинэчилсэн найруулга хийснээр уул уурхайн хөрөнгө оруулалт, хайгуулын

болон ашиглалтын үйл явц ямар байх талаар тодорхой тусгаж өгсөн. Энэ хууль болон бусад холбогдох хуулиуд нь улс үндэстний ирээдүйг цогцлоох хууль эрх зүйн үндэс суурь болж байна.

Ашигт малтмалын

тухай болон 1995 оны Байгаль орчныг хамгаалах тухай гэх мэт бусад хуулиуд нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход иргэдийг оролцуулах үндсэн суурийг хангасан байдаг. Монгол оронд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд иргэдийн оролцоо, хяналт зайлшгүй чухал ач холбогдолтой. Хөдөө орон нутагт амьдардаг иргэд, малчид өөрсдөө уул уурхайн үйл ажиллагаанаас орон нутагтаа ямар нэг хэмжээгээр ашиг оруулах талаар бодож өөрсдийн эрх ашгийн төлөө зогсох хэрэгтэй юм. Өөрийн газар нутаг, гол мөрөн, амьтан ургамал болон нөөц баялагтай холбоотой шийдвэр гаргахад иргэд санал бодлоо хэлэхгүй бол өөрсдийнх нь сонирхол, эрх ашигт нь нийцэхгүй эдийн засаг, улс төрийн шийдвэртэй тулгаран амьдрах болно.

Уул уурхайн үйл ажиллагаа болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох нь техникийн үйл ажиллагааны, асуудал билээ. Тэгвэл яагаад жирийн иргэд үүнд оролцох хэрэгтэй вэ? Энэ



асуулгын хариулт нь энгийн, иргэдийн оролцоо нь өөрсдийн амьдрал болон орон нутгийн ирээдүйн хөгжлийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Иргэдийн оролцоогүйгээр уул уурхайн үйл ажиллагаа зогсохгүй, харин тухайн орон нутгийн газар болон усны нөөцтэй холбоотой, ард иргэдийн ашиг сонирхолтой нийцэх нийцэхгүй шийдвэрийг бусад хөндлөнгийн хүмүүс гаргана гэсэн үг юм.

Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, улс төрийн ардчилсан тогтолцоо нь иргэдийн оролцоог хангасан хүчтэй зэвсэг юм. Иргэд нь төрийн үйл ажиллагаанд ба нөөц баялагийг ашиглах шийдвэр гаргах явцад оролцох олон арга замууд байдаг ба энэхүү гарын авлага нь ашигт малтмалын хайгуулын болон ашигдалтын тусгай

зөвшөөрлийг олгох журмын аль шатанд, хэрхэн иргэд оролцож болох талаар тодорхой өгүүлсэн билээ.

Энэхүү гарын авлага нь анхны хэвлэл бөгөөд үүнийг иргэд орон нутагтаа авч ашиглан, санал бодлоо бидэнтэй хуваалцаж, гарын авлагыг цаашид улам боловсронгуй болгох үйлсэд хувь нэмрээ оруулна гэж Азийн сан найдаж байна. Та санал бодлоо wqmpprogram@asiafound.mn гэсэн хаягаар илгээнэ үү.

Уг гарын авлагыг Нидерландын Вант улсын Засгийн газрын тусламжаар Азийн сангаас хэрэгжүүлж буй “Ирээдүйгээ баталгаажуулах нь” байгаль орчныг хамгаалах санаачлага болон тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих цогц хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэн боловсруулав.

Талархал

Энэхүү гарын авлагыг бэлтгэн гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудыг төлөөлсөн олон хүн үнэтэй зөвлөгөө өгч тусалсан бөгөөд байгууллага, хувь хүмүүстэй мэдээлэл солилцохдоо бид үргэлж баяртай байдаг билээ. Бидэнд мэдээлэл, зөвлөгөө өгч тусалсан Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц. Шийрэвдамба, газрын дарга А. Энхбат; Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх А. Мягмарсүрэн; Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын ажилтан О. Энхтуяа; Дэлхийн байгаль хамгаалах сангийн Б. Чимэд-Очир; Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Ханс Хофман, Ариун суварга хөдөлгөөний тэргүүн Г. Чагнаадорж; Хөвсгөл далайн эзэд

хөдөлгөөний тэргүүн Б. Баярмаа; Хонгор нутгийн дуудлага хөдөлгөөний тэргүүн Д. Батболд болон Тосон Заамар–Туул гол хөдөлгөөний тэргүүн Д. Энхтөр нарт талархаж буйгаа илэрхийлж байна.

АНУ-ын Азийн сангийн ажилтнууд хамтарч уг гарын авлагыг гаргасан ба Оюунчимэг Финч гол зохиогчоор ажиллаж, Уильям С. Инфанте, Эдвард Делхаген, Ц. Баярмаа нар бодлого, хуулийн талын болон бусад чухал мэдээллээр хангаж, Шила Розентал англи эхийг, Х. Баярмаа монгол орчуулгыг хянан тохиолдуулав.

Гарын Авлагын Зорилго

Энэхүү гарын авлагад ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой төрөөс гаргах шийдвэрт Монгол улсын иргэд хэрхэн хяналт тавьж, мэдээлэл авах талаар өгүүлсэн билээ. Дараахь бүлгүүдэд уул уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө **хайгуулын** болон **ашиглалтын** тусгай зөвшөөрөл олгох үйл явцад иргэд хэзээ, хэрхэн оролцож болохыг тодорхой болгож өгсөн ба доор дурьдсан зүйлүүдтэй холбоотой мэдээллийг орууллаа. Үүнд:

- ◆ Олон нийтийн оролцоо, иргэдийн хяналт хийх болон шийдвэрт оролцох эрхийг бүрдүүлж буй хууль эрх зүйн заалтууд
- ◆ Олон нийтийн оролцооны зарчим, арга зам, бүтэц зохион байгуулалт болон ач холбогдол
- ◆ Ашигт малтмалын *хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл* олгох журам
- ◆ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход холбоотой төрийн эрх бүхий байгууллагууд
- ◆ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоходоо байгалийн нөөц баялгийг хамгаалах, талаар хүлээх засгийн газрын үүрэг хариуцлага
- ◆ Орон нутгийн иргэд уул уурхайн үйл ажиллагаанд тавих хяналтыг үр өгөөжтэй болгохын тулд хэрэгтэй мэдээллийг хаанаас, хэрхэн олж авч болох
- ◆ Маргааныг хэрхэн шийдвэрлэх

1

Иргэдийн эрх, үүрэг



Монгол улсын иргэд Үндсэн хууль болон бусад олон хууль, тогтоомжинд заасанчлан нэлээд эрх мэдэл, эрх, эрх чөлөөг эдлэх эрхтэй байдаг боловч ард түмэн өөрсдийгөө ийм давуу эрхтэй гэдэг ойлголт хомс байдаг. Хууль тогтоомжинд ямар нэгэн зөрчил, доголдол байгаагаас бус харин иргэд өөрсдөө хууль эрх зүйн мэдлэггүйн улмаас эрх, эрх чөлөөгөө эдэлж чаддаггүй байна. Энэхүү бүлэгт иргэдийн хуулиар олгогдсон зарим эрх үүргийн тухай өгүүлсэн. Хэрэв бусад хуулиудыг судлаж үзвэл шийдвэрт оролцох, иргэдийн оролцоог хангасан бусад олон заалтыг ч олж болох юм. Уг гарын авлагыг уншиж, ашиглах хүмүүс өөрсдийн олж тодорхойлсон хуулийн заалтууд болон санал бодлоо илэрхийлж, уг гарын авлагыг хожим боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Монгол улсын Үндсэн хуулиар олгогдсон эрх

Үндсэн хууль нь иргэний үндсэн эрхүүдийг олгосон бөгөөд Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн 3.1-р зүйл нь хамгийн чухал заалт *“Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”* гэж заасан байдаг.

Бусад эрх:

1. Эрүүл орчинд амьдрах • Иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй. (2-р бүлгийн 16.2-р зүйл)

2. Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах

• Иргэд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно. (2-р бүлгийн 16.16-р зүйл)

3. Мэдээлэл олж авах • Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. (2-р бүлгийн 16.17-р зүйл)

4. Төрийн үйл ажиллагаанд оролцох:

- ◆ Иргэд шууд буюу төлөөлөгчийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. (2-р бүлгийн 16.9-р зүйл)
- ◆ Иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. (2-р бүлгийн 16.12-р зүйл)
- ◆ Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална. (3-р бүлгийн 23.1-р зүйл)

Иргэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэхийн хажуугаар үүргээ биелүүлэх ёстой.

Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн. (2-р бүлгийн 17.2-р зүйл)

Бусад хууль тогтоомжоор олгогдсон иргэний эрх

Үндсэн хуулиас гадна Улсын Их Хурлаас батлан гаргасан хэд хэдэн хуулинд иргэдийн гүйцэтгэх үүрэг, түүний дотор байгаль хамгаалах, байгалийн баялгийг

ашиглах, байгалийн нөөцийг хууль бусаар ашиглаж буй үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус үйл ажиллагаанд ямар нэг хэмжээгээр нөлөө үзүүлэх болон байгалийн нөөцийг ашиглах, түүний дотор уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийг илүү боловсронгуй, өргөн хүрээтэй болгож өгсөн билээ.

Иргэд шууд болон төлөөлөгчдийн байгууллагуудаараа дамжуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт оролцох болон хяналт тавих, бусад оролцох эрхийг байгаль орчин, ашигт малтмал, захиргааны үйл ажиллагаатай холбоотой харьцангуй олон хуулинд зааж өгсөн байдаг. Мөн эдгээр болон бусад хуулинд иргэд мэдээлэл олж авах нэлээд өргөн хүрээтэй арга замыг тусгасан. Жишээ нь: иргэд, иргэдийн нөхөрлөл нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авах өргөдлийн тухай мэдээллийг холбогдох байгууллагаас авч болно. Мөн байгаль орчныг хамгаалах талаар гаргасан засаг даргын тайлан, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан төсвийн тайлан болон сум (дүүрэг), багийн байгаль хамгаалахтай холбоотой тайлангуудтай танилцаж болно. Мэдээлэл олж авах талаар зарим тодорхой хуулийн заалтыг доор дурдлаа.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Иргэд дараахь эрхийг эдэлнэ. Үүнд:

- ◆ Иргэд байгаль орчныг хамгаалах тухай хууль (БОХТХ) тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах. (Нэгдүгээр бүлэг, 4.1.2-р зүйл)
- ◆ Иргэд байгаль орчныг хамгаалах

олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх. (Нэгдүгээр бүлэг, 4.1.3-р зүйл)

- ◆ Иргэд холбогдох байгууллагаас байгаль орчны талаарх үнэн, зөв мэдээллийг авах. (Нэгдүгээр бүлэг, 4.1.4-р зүйл)

- ◆ Байгаль орчинд хортой нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргах болон байгаль орчинд хортой нөлөө үзүүлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах. (Нэгдүгээр бүлэг, 4.1.5-р зүйл)

- ◆ Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд зохих төлбөр хураамжийг төлж гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу байгалийн баялагийг ашиглаж болно. (Нэгдүгээр бүлэг, 6.2-р зүйл)
- ◆ Төр болон төрийн байгууллага, албан тушаалтан нь гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялагийг хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг нөхөрлөлд хариуцуулах хэлбэрээр байгаль орчныг хамгаална. (Дөрөвдүгээр бүлэг, 19.2.7-р зүйл)
- ◆ Байгаль орчныг хамгаалах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд гэрээний үндсэн дээр хамгаалахаар хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялагийг хуулийн хүрээнд

гэрээнд заасны дагуу зохистой ашиглах, эзэмших давуу эрхтэй байна. (Зургадугаар бүлэг, 31.1-р зүйл)

- ◆ Иргэд нөхөрлөл байгуулж, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад хуулийн хүрээнд тодорхой төрлийн нөөц баялагийг хамгаалах,

ашиглах эрхээс гадна уул уурхайн шийдвэрт оролцох болон үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй. Иргэдийн нөхөрлөл нь үйл ажиллагаагаа Байгаль Орчны Сайдын 2006 оны 4 сарын 26-ны өдрийн 114 тушаалын хавсралт журмын дагуу явуулна.¹

Иргэд байгаль орчныг хамгаалах дараахь үндсэн үүргийг биелүүлнэ. Үүнд:

- ◆ Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг сахин биелүүлэх (Нэгдүгээр бүлэг, 4.2.1-р зүйл)
- ◆ Байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж, хэрэглэх, үр хүүхдэдээ экологийн хүмүүжил олгох (Нэгдүгээр бүлэг, 4.2.2-р зүйл)
- ◆ Байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх (Нэгдүгээр бүлэг, 4.2.3-р зүйл)
- ◆ Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалахын тулд эдийн засгийн зорилгоор байгалийн нөөцийг ашиглаж байгаа иргэд, бизнес эрхэлж буй аж ахуйн нэгжүүд, байгууллагууд

1 - Иргэдийн нөхөрлөлийн талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл Азийн сангаас гаргасан "Иргэдийн нөхөрлөлөөр дамжуулан байгалийн баялагийг хамгаалж, ашиглах" Олон нийтэд зориулсан гарын авлагыг үзнэ үү.

байгалийн баялаг ашигласан газар,
орчныг засаж сайжруулах, тохижуулах
(Дөрөвдүгээр бүлэг, 25.1.2-р зүйл)

Хуулийн хоригууд

Монгол Улсын Тусгай хамгаалалттай
газар нутгийн тухай хуулинд зарим газарт
тэсэлгээ хийх, газар ухах; ашигт малтмал
хайх, олборлох; элс, хайрга, чулуу авах;
мод бэлтгэх зэргээр байгалийн унаган

төрхийг алдагдуулах үйл ажиллагааг дараах
газруудад явуулахыг хориглосон байдаг:

- ◆ Тусгай хамгаалалттай газар (12.1-р зүйл)
- ◆ Байгалийн цогцолбор газар (18.1-р зүйл)
- ◆ Байгалийн нөөц газар (21.2-р зүйл)
- ◆ Байгалийн болон түүхийн дурсгалт зүйлс (24.2-р зүйл) тус тус орно.

1-р хайрцаг: БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗАР



Байгалийн нөөц газар нь хэд хэдэн янз байж болох ба биологийн болон палеонтологийн чухал нөөц баялгийг агуулж байдаг. Үүнд: ховордсон ургамал амьтан, байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх зорилготой газар багтана. Мөн нөөц газарт төрөл зүйлийн тархацын менежментийн талбай; байгалийн өвөрмөц тогтцыг хамгаалах геологийн нөөц газар; гол, горхи, нуурыг хамгаалах усны нөөц газар орно.

2

Ашигт малтмалын лиценз олгох үйл явцад иргэдийг үр дүнтэйгээр татан оролцуулах арга зам



Уул уурхайн компани нь ашигт малтмалын ямар нэгэн үйл ажиллагаа явуулахын тулд хэд хэдэн тусгай зөвшөөрөл авсан байх ёстой бөгөөд эхлээд хайгуулын, дараа нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авна. Эдгээр тусгай зөвшөөрлийг олгох үйл явцад иргэд хэд хэдэн удаа оролцох боломж олгогдсон байдаг. Гэтэл газар ашиглалтын шийдвэрт оролцох хамгийн оновчтой үе нь аль нэгэн компани болон хувь хүмүүс ашигт малтмал, төмөрлөгийн, эсвэл бусад нөөц баялагийн хайгуул хийхээс өмнөх үе юм.

Иргэд өөрсдийн хүссэн зорилгодоо хүрэхийн тулд тухайн орон нутгийн байгууллагуудаар дамжуулан төлөөлөгч байгууллагуудын үйл ажиллагаанд оролцож болно. Монгол улсын хуулиар энэхүү эрх чөлөөг иргэдэд олгосон байдаг. Тусгай зөвшөөрөл олгох үйл явц эхлэхээс өмнө иргэд ямар бэлтгэлтэй байх шаардлагатайг доор дурьдав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөтэй танилцах, санал бодлоо тусгах

Иргэд сум, аймгийн засаг даргын болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын (ИТХ) байгаль хамгаалах төлөвлөгөөтэй танилцах, санал бодлоо илэрхийлэх, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд, засаг дарга гэх мэт холбогдох байгууллага, хүмүүсээс хариу авах эрхтэй. Иргэд доорх асуултуудыг асуун, саналаа оруулж болно. Үүнд:

- ◆ Орон нутагт маань байгалийн нөөц баялаг, байгаль орчны талаарх тулгамдсан асуудлууд юу байна вэ? Орон нутагт маань байгалийн ямар өв, баялаг байна

ЭРТ, БАЙНГЫН ОРОЛЦОО

Тухайн орон нутгийн иргэдийн амьдрал, байгаль орчинд нөлөөлөх аливаа үйл ажиллагааг эхлэхээс нь өмнө иргэд хяналт тавьж чадвал иргэдийн оролцоо үр дүнтэй болдог. Орон нутагтаа юу болж байгааг мэдсэнээр иргэд төлөвлөгдсөн үйл ажиллагаа эхлэхээс өмнө гарч болох өөрчлөлтүүдийн талаар илүү мэдээлэлтэй болсон байдаг.

Иргэд тухайн нутагт орших голын усны чанар, амьтдын амьдрах орчин, гадаргын ус, орон нутгийн эдийн засаг, эрүүл мэндийн талаарх санаа зовоосон асуудал, газар ашиглалтын хэлбэр гэх мэт олон зүйлсийн талаарх мэдээллийг цуглуулж идэвхитэй оролцож болно. Үүнээс гадна төрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөтэй танилцаж, мэдээлж болно. Өөрийн орон нутгийн асуудлуудын талаар сайн мэдсэнээр иргэд ардчилсан нийгмийн идэвхитэй оролцогчид болж, уул уурхайн компани болон нөөц баялагийг ашиглахыг сонирхож байгаа бусад аж ахуйн нэгжүүд ирж үйл ажиллагаа явуулахад оновчтой оролцох боломжтой болно.

вэ? Бид бүхний мэдэх ямар ямар асуудлууд байна вэ? Ямар зүйлс бидэнд үнэ цэнэтэй вэ?

- ♦ Орон нутагт маань байгаль хамгаалах төлөвлөгөө байна уу? Байгаа бол хэзээ боловсруулж гаргасан бэ? Хамгийн сүүлд хэзээ шинэчилсэн бэ? Тухайн төлөвлөгөө нь иргэдийн урт хугацааны сонирхол, эрх ашгийг хамгаалж чадаж байна уу?
- ♦ Байгаль хамгаалах төлөвлөгөөний төсвийн хэмжээ ямар байна вэ? Хэн уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд

зарцуулагдах төсвийг баталдаг вэ? Төсвийн зарцуулалт ямар байна вэ?

- ♦ Орон нутгийн тусгай хэрэгцээ юу байна вэ? Хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байна вэ, эсвэл хангахгүй байна уу?
- ♦ Тулгамдсан асуудлуудыг хэн шийдвэрлэх вэ? Эдгээр асуудлуудыг шийдвэрлэх ямар арга зам байна вэ?

Уул уурхайн талаар мэдээлэл, мэдлэг олж авах

Орон нутгийн иргэд ашигт малтмалын үйл ажиллагаанд үр дүнтэй, итгэл дүүрэн оролцохын тулд уул уурхайн үйл ажиллагааны талаар мэдлэг, ойлголттой байх хэрэгтэй юм. Иргэд эхлээд ямар төрлийн ашигт малтмалын үйл ажиллагаа явагдах гэж байгааг мэдэх хэрэгтэй бөгөөд үүнд цаг зав гарган судалгаа хийж, шургуу зүтгэх хэрэгтэй бөгөөд мэдээлэл авах нөөц бололцоо нь нээлттэй юм.

Ашигт малтмал нь үндсэн орд ба шороон орд гэсэн хоёр үндсэн төрлөөс бүрддэг. Үндсэн орд гэдэг нь газрын гадарга болон газрын гүнээс ухаж гаргаж авсан хатуу чулуулаг бөгөөд уг чулуулгаас төмөрлөг, ашигт малтмал, эсвэл барилга байгууламжийн материалыг гаргаж авдаг ба үндсэн орд нь хатуу чулуун давхаргад оршдог. Шороон орд гэж төмөрлөг, ашигт малтмал нь гол төлөв элэгдлийн улмаас анх байсан газраасаа зөөгдөн шилжсэнийг хэлэх бөгөөд шороон орд нь голын хөндий, ай савуудад элбэг тохиолдоно. Аль ч ашигт малтмалын үйл ажиллагаа нь ажилчдын аюулгүй байдал, химийн аюултай бодисуудыг хэрэглэх (цианит, мөнгөн ус гэх мэт), усанд үзүүлэх нөлөө, уурхайн үйл ажиллагаа дуусч хаах, ашигласан газарт нөхөн сэргээлт хийх,

тэвэрлэх гэх мэт асуудлуудтай тулгарч байдаг. Иргэд эдгээр ерөнхий зүйлсийн талаар асууж лавлан, мэдэж судалснаар уул уурхайн үйл ажиллагаа тэдэнд ямар ашиг тустай эсвэл ямар хор хохиролтой гэдгийг мэдэж авна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаар ойлголттой байх

Иргэдийн оролцооны 2 дахь бүрэлдэхүүн хэсэг нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбогдох төрийн байгууллагуудын талаар мэдлэгтэй байхыг шаарддаг. Үүнд газар зүйн зураг болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгодог, байгаль орчныг хамгаалж, хяналт шалгалт явуулдаг, усны чанарын судалгаа шинжилгээ хийдэг чухал үүрэг гүйцэтгэдэг төрийн хэд хэдэн байгууллага багтана. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явцтай танилцсанаар иргэд тухайн орон нутагт ямар үйл ажиллагаа явагдах болон хэзээ, хаана хөндлөнгөөс оролцож болох талаар ойлголттой болох ба доорх асуултуудын хариуг олж мэдэх нь чухал юм:

- ◆ Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хаанаас авч болох вэ? Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг ямар эрх бүхий байгууллага, хаана олгодог вэ? Ямар үндэслэлээр шийдвэр гаргадаг вэ?
- ◆ Иргэд тусгай зөвшөөрөл олгох үйл явцад хэрхэн оролцож болох вэ? Тусгай зөвшөөрөл олгох үе шатуудад хэрхэн санал бодлоо илэрхийлж оролцож болох вэ?
- ◆ Уул уурхайн үйл ажиллагаа зохих дүрэм журмаараа явагдахгүй байгаа тохиолдолд иргэд хэнд хандаж энэ

ИРГЭД УУЛ УУРХАЙН КОМПАНИАС ЮУ ХҮСДЭГ ВЭ?

Орон нутгийн иргэд уул уурхайн компанийг орон нутагтаа хүлээн авахад бэлэн байдаг гэсэн тууштай хариулт өгсөн боловч иргэд уул уурхайн компаниас доорх зүйлсийг хийхийг хүсдэг. Үүнд:

- ◆ Өөрсдийг нь шийдвэрт оролцуулах, мэдээллээр хангах
- ◆ Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах
- ◆ Уурхайн үйл ажиллагаа явуулсан газраа нөхөн сэргээж хэвийн байдалд нь оруулах

ИРГЭД ОРОН НУТАГТАА ЯМАР ХҮСЭЛ ЭРМЭЛЗЛЭЛТЭЙ ВЭ?

Монгол улс даяар орон нутгийн үүсгэл санаачлагын байгууллагуудтай уулзахад, дараахь нийтлэг хүсэл эрмэлзлэлтэй байдгаа илэрхийлсэн:

- ◆ Орон нутгийнхаа дахин давтагдашгүй түүх, соёлыг хадгалж үлдэхийг иргэд хүсдэг.
- ◆ Залуучуудыг орон нутагтаа амьдарч, гэр бүлээ цогцлоохыг иргэд хүсдэг.
- ◆ Ажлын байр бий болгодог эдийн засгийн хөгжлийг иргэд хүсдэг.

тухай мэдэгдэж болох вэ?

- ◆ Хаана уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглосон бэ? Яагаад хориглосон бэ?
- ◆ Тусгай зөвшөөрөл авахад уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг этгээд нь

байгаль орчныг хамгаалах талаар юу хийх шаардлагатай вэ?

- ◆ Байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөө болон уул уурхайн үйл ажиллагаа дуусч, хаахад ямар шаардлагууд тавигддаг вэ?
- ◆ Уурхайн үйл ажиллагаа дуусахад, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд хэн хяналт тавьж шалгадаг вэ?

Эдгээр болон бусад асуултын хариултыг Хавсралт 2-оос авч болно.

Өөрийн орон нутагт олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл олж авах

Уул уурхайн үйл ажиллагаанаас бий болдог эерэг болон сөрөг үр дагаварын талаар хөдөө орон нутгийн олон иргэд тодорхой туршлагатай болсон. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох журам нь Ашигт малтмалын тухай хуулинд заагдсан ба энэхүү хууль нь батлагдаад хэдэн жил болж байгаа бөгөөд уул уурхайн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл авах тусгай шат дамжлагуудыг дамжсан байдаг. Иргэд төрийн захиргааны байгууллагын холбогдох ажилтнаас өөрийн орон нутагт урьд өмнөх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь хэрхэн олгосон талаар асууж лавлан мэдэж авч болно. Засаг захиргааны ямар нэгж оролцсон, хэн тусгай зөвшөөрөл олгосон бэ? Зөвшөөрөл нь хууль журмын дагуу олгогдож уу, үгүй юү? Хууль журмын дагуу олгогдоогүй бол яагаад? Уул уурхайн үйл ажиллагаа зохих ёсоор, тусгай зөвшөөрлийн дагуу явагдаж байна уу, үгүй юү? Өмнө олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн

талаар тухайн орон нутгийн иргэд мэдэж авсанаараа туршлагатай болж, ирээдүйд үйл ажиллагаа явуулах уул уурхайн компаниудад тусгай зөвшөөрөл олгох үйл явц ямар байх ёстойг мэдэж ойлгоход нь тус дөхөм болно.

Уул уурхай нь хэрхэн нийгэм, эдийн засгийн ашиг орлогыг нэмэгдүүлдэг талаар мэдэж авах

Уул уурхай нь эдийн засгийн ашгийн төлөө үйл ажиллагаа бөгөөд уул уурхайн олборлолт явуулснаараа хөрөнгө оруулагч болон эзэд нь ашиг олж байдаг. Уурхайд хүмүүсийг авч ажиллуулж, мөн улсад төрөл бүрийн татвар төлснөөр тухайн улсын эдийн засгийн өсөлтөд тус нэмэр болж байдаг төдийгүй үйл ажиллагаа явуулж буй тухайн орон нутгийн эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулхаас гадна нийгмийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлдэг. Иргэд орон нутагт нь явагдаж буй уул уурхайн үйл ажиллагаанаас олох ашиг орлогын хэмжээ болон орлогыг хэрхэн хувиарлах талаар доорх асуултаудын дагуу мэдээлэл олж авч болно. Үүнд:

- ◆ Уул уурхайн ашгаас хэн, хэрхэн хүртэх вэ? Уул уурхайн компани тухайн орон нутгийн хүмүүсийг авч ажиллуулах уу? Уул уурхайн компани тухайн орон нутагт хэрхэн хөрөнгө оруулалт хийх вэ?
- ◆ Уул уурхайн үйл ажиллагаанаас ноогдох ашгийн хувиарлалтыг орон нутагт хэн хийх эрхтэй вэ?
- ◆ Бусад аймаг, сумынхан хэрхэн уул уурхайн компанитай зөвшилцөж, тохиролцоонд хүрсэн байна вэ?
- ◆ Уул уурхайн компанийн төлсөн

татвараас орон нутгийнхан ашиг хүртэх үү?

- ◆ Уул уурхайн орлогын хуваарилалтын талаар Монгол улсын хуулинд хэрхэн тусгасан байдаг вэ?

Дээрх төсөв, татвартай холбоотой зүйлсийг энэхүү гарын авлагад дэлгэрэнгүй дурдаагүй хэдий ч иргэд тогтвортой байдлын гэрээ, уул уурхайн үндэсний бодлогын талаар бусад эх сурвалжуудаас мэдэж авч болно.

Орон нутагт ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах сонирхолтой компаниудын талаар мэдээлэлтэй байх

Ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах сонирхолтой этгээд нь тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргах явцад тухайн компанийн талаар болон үйл ажиллагааных нь тайлангийн талаар мэдэх цаг, боломж орон нутгийн иргэдэд байдаг. Уул уурхайн компаниуд олон талаар харилцан адилгүй байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй. Зарим компани ашигтай ажиллаж чадаж байхад зарим нь эдийн засгийн хувьд төдийлөн ашигтай ажиллаж чаддаггүй. Зарим компани олон улсын шилдэг технологи, практикийг нэвтрүүлж байхад зарим нь хүний эрх болон байгаль орчныг үл ойшоон хайхрамжгүй ханддаг

байна. Мөн зарим компани тухайн орон нутгийн иргэдийн ашиг сонирхлыг харгалзан үзэж, тэднийг оролцуулан үйл ажиллагаагаа явуулдаг байхад бусад компаниуд тэгдэггүй.

Интернэт хөгжсөн өнөө үед уул уурхайн компаниудын одоогийн хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа, түүх, нэр хүнд нь хэр түвшинд байгаа талаар мэдэж авахад илүү хялбар болж байна. Уул уурхайн компаниуд орон нутгийнхан болон байгаль орчинд хэрхэн хандаж байгаа талаар иргэд мэдэж авсанаараа тэдгээр компанитай хэрхэн ажиллах арга хэлбэрээ тодорхойлох боломжтой болно.

Анхаарах зүйл: Компаниудын өмнөх үйл ажиллагааны үзүүлэлт нь ирээдүйд хэрхэн үйл ажиллагаа явуулна гэсэн баталгаа болохгүй гэдгийг бодож үзэх нь зүйтэй юм. Яагаад гэвэл муу компани үйл ажиллагаагаа сайжруулж байхад заримдаа сайн компаниуд ч алдаа гаргаж магадгүй юм. Сонор сэрэмжтэй иргэд орон нутагтаа үйл ажиллагаа явуулах гэж буй компаниудаас орон нутгийн хүмүүсийн сайн сайхан байдал, ашиг сонирхлыг хамгаалах болон оролцогч талууд гарч

болох эрсдлийг хамтдаа үүрч, олох ашгаас мөн зохих ёсоор хүртэх болно гэсэн баталгааг гаргуулж авахыг зорих хэрэгтэй юм. Энэ ямар утга агуулж байна гэвэл ашигтай ажиллаж байгаа компаниуд нь тухайн орон

нутгийн боловсрол, эрүүл мэнд болон бусад үйлчилгээнд хөрөнгө оруулах илүү бололцоотой юм. Ийм хөрөнгө оруулалтыг ашигт малтмалын үйл ажиллагаа эхлэхээс өмнө тодорхой төлөвлөх нь чухал бөгөөд ингэснээр



уул уурхайн компани үйл ажиллагаа нь амжилттай явагдвал орон нутагт хөрөнгө оруулалт хийх магадлал өндөр байх болно.

Бусад бүс нутгийн болон улс орны иргэдээс суралцах, мэдээ мэдээлэл солилцох

Бусад аймаг, сум, багуудын иргэдтэй холбоо тогтоон, сүлжээ бий болгосноороо иргэд өөрсдийн сурч мэдсэн зүйлсээ бусадтай хуваалцан, бусдаас сурч мэдсэн

зүйлсээ өөрийн нутагтаа хэрэгжүүлэх боломжтой болдог. Ижил юм уу төсөөтэй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гэж байгаа хүмүүс салангид, уялдаа холбоогүй ажиллах нь үр нөлөө багатай ба мэдлэг, мэдээллийг олж авах боломжийг хязгаарладаг. Бусад орон, аймаг, сумын хүмүүс илүү мэдлэг, мэдээлэл, туршлагатай байж болох ба тусалцаа үзүүлж чадна. Мэдээлэл бол чухал зэвсэг бөгөөд уялдаа холбоотой хамтын ажиллагаа нь уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог илүү үр дүнтэй болгодог.



3

Хайгуулын лиценз олгох үйл явцад иргэдийг оролцуулах арга зам



Тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг мэдэж авах нь иргэд шийдвэр гаргах үйл ажиллагаанд илүү үр дүнтэй оролцох үндсэн нөхцөл болдог. Энэхүү бүлэгт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох шат дарааллууд болон аль үе шатанд нь иргэд оролцож болох талаар өгүүлсэн билээ. 1-р зурагт Монгол улсад тусгай зөвшөөрөл олгох үйл явцад иргэд хэрхэн, ямар журмаар оролцох боломжийг харууллаа.

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу аливаа ашигт малтмалын эрэл, хайгуул болон ашиглалтын үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ (5-р хайрцгаас харна уу). Газрын гадарга, хөрсийг сүйтгэлгүй, агаараас зураг аван, геологи, ашигт малтмалын анхдагч мэдээллийг ашиглан судалгаа хийхийг тойм судалгаа гэх бөгөөд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй.¹

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Ашигт малтмалын тухай хуулийн (АМТХ) Гуравдугаар бүлэгт заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг дараахь журмын дагуу олгоно:

- ◆ Өргөдөл гаргах – Ашигт малтмалын хайгуул хийх хүсэлтэй хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд өргөдлөө Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газарт (АМГТХЭГ) шаардлагатай хавсралт материалын хамт өгнө. Шаардлагатай

¹ Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон, түүнчлэн тусгай хэрэгцээ болон нөөцөд аваагүй нутаг дэвсгэрт хуулийн этгээд тойм судалгааг тусгай зөвшөөрөлгүйгээр явуулж болох бөгөөд судалгаа явуулах талбай, түүний байршил, өөрийн нэр хаягийг төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдэж бүртгүүнэ. (АМТХ-ийн 3-р бүлгийн 15.1-р зүйл)

материалд өргөдөл гаргагчийн нэр, холбоо барих утасны дугаар, аж ахуйн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хууль, хайгуул хийх талбайн газрын зураг, төлбөрийн баримт, боловсон хүчний чадавхийн тодорхойлолт, ажлын төлөвлөгөө зэрэг багтана. (18.2-р зүйл)

- ◆ Өргөдлийг хянаж үзэх – Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар өргөдлийг хүлээж аван бүртгэж, хайгуул хийх талбайн өнцгийн координатуудыг шалгана. Хайгуул хийх талбай нь улсын тусгай хэрэгцээний газар, нөөцөд авсан талбай болон хайгуулын талбайд хамруулах боломжгүй гэж үзсэн нуур, цөөрөм зэрэг байгалийн цогцолбор газартай давхцаж болохгүй. (6-р хайрцгийг үзнэ үү) Хайгуул хийх талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 400 мянган гектараас ихгүй байна. Хэрэв АМГТХЭГ нь өргөдөл гаргагч бүх шаардлагыг хангаж байгаа хэмээн үзэж байгаа бол зөвшөөрлийн нөхцлийг болон хүсэлтэд дурдсан талбай нь түрүүлж ирсэн өргөдөлд дурьдсан талбайтай давхцсан, үгүйг өргөдөл гаргагчид мэдэгдэнэ гэж АМТХ-д заасан байдаг. (19.2-р зүйл)
- ◆ Орон нутагт мэдэгдэх – Хуулийн дагуу, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд АМГТХЭГ нь энэ талаар тухайн хайгуул явагдах аймаг, нийслэлийн засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд төлөвлөгдсөн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт болон төлөвлөгдсөн талбайн зургийг хавсаргана. (19.3-р зүйл)
- ◆ Иргэдийн оролцоо – Аймаг, сум, нийслэлийн засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийн

талаарх мэдэгдлийг хүлээн авмагц холбогдох шатны ИТХ-аас саналыг нь авна. Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор АМГТХЭГ-т хариу өгөх бөгөөд 30 хоногийн дотор хариу өгөхгүй бол тухайн тусгай зөвшөөрлийг олгоно.

30 хоногийн дотор иргэд эрхийнхээ дагуу ИТХ-аараа дамжуулан өөрсдийн санал бодлоо илэрхийлж, төлөвлөгдсөн уул уурхайн үйл ажиллагаа нь аймаг, сум, багийн байгаль хамгаалах төлөвлөгөөтэй хэрхэн хамааралтай байгаа талаар болон 2-р бүлэгт өгүүлсэн асуултаудыг асууж лавлаж болно. Засаг дарга Ашигт малтмалын тухай хуульд заасан үндэслэлээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу өгч болно. (19.4-19.5-р зүйл)

- ◆ Эцсийн шийдвэр – Аймаг, нийслэлийн засаг дарга дэмжсэн шийдвэр гаргасан бол АМГТХЭГ өргөдөл гаргагчид хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эцсийн шийдвэрийг гаргана. (19.6-р зүйл)
- ◆ Тусгай зөвшөөрөл хүлээн авагчийн хийх төлбөр – Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг зөвшөөрөл хүсэгч ажлын 10 өдөрт багтаан төлнө. (Ашигт малтмалын хайгуулын болон ашигдалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн тухай Хавсралт 1 –ээс харна уу). Хэрэв өргөдөл гаргагч эхний жилийн төлбөрийг хуулинд заасан хугацаанд хийгээгүй бол өргөдлийг бүртгэлээс хасч өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ. Эхний жилийн төлбөрөө хугацаанд нь хийсэн тохиолдолд АМГТХЭГ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгоно. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр,

5-р хайрцаг

АШИГТ МАЛТМАЛЫН НЭР ТОМЪЁО

- ◆ **Хайгуулын ажилд** ашигт малтмалын судалгаа, сорьц авах, газрын гүн рүү өрөмдөж дээж авах зэрэг ажлууд хамрагддаг. Хайгуулын ажлын үр дүнд тухайн нутгийн газрын хөрсөнд байгаа үнэт баялаг, ашигт малтмалын төрөл, тархацын хэмжээг тогтоох цаашид тухайн ашигт малтмалыг ашиглахад гарах эдийн засгийн үр ашгийг тооцоолж гаргана.
- ◆ “Ашигт малтмалын хайгуул” гэж газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, ашигт малтмалын байршил, чанарыг тогтоож, тэрхүү ашигт малтмалыг олборлох техник, эдийн засгийн боломжийг тодорхойлох үйл явц юм. (AMTX, Нэгдүгээр бүлэг, 4.1.5-р зүйл)
- ◆ **Ашигт малтмал олборлох** гэдэг нь газрын өнгөн хөрсийг хуулах, газрыг ухах, газар ухан ашигласан усаа хуримтлуулж, химийн бодисыг тунгаах зорилгоор цөөрөм тогтоох, химийн бодис ашиглан хүдрийг гаргаж авах, бутлах юмуу хүдрийг цуглуулж баяжмал болгох үйл явц орно. Уурхай нь ил, далд гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Ашигт малтмалыг бүрэн ба бүрэн бус олборлодог уурхайн компаниуд байдаг ба бүтээгдэхүүнээ зах зээл дээр зарах юм уу эсвэл үнэ нь хүссэн хэмжээнд хүрэн өсөх хүртэл хуримтлуулж хадгалдаг.
- ◆ “Ашигт малтмал ашиглах” гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг хэлнэ. (AMTX, Нэгдүгээр бүлэг, 4.1.6-р зүйл)
- ◆ **Тусгай зөвшөөрөл олгох** гэдэг нь эрх бүхий байгууллага хуулийн өмнө хариуцлага хүлээх чадвар бүхий аж ахуйн нэгжид тухайн тусгай зөвшөөрөлд тусгасан үйл ажиллагааг явуулах эрх олгох үйл явц юм.
- ◆ **Хайгуулын тусгай зөвшөөрөл** гэж AMTX-ийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олгосон баримт бичгийг хэлнэ. (AMTX, Нэгдүгээр бүлэг, 4.1.14-р зүйл)
- ◆ **Ашиглалтын тусгай зөвшөөрөл** гэж AMTX-ын дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичгийг хэлнэ. (AMTX, Нэгдүгээр бүлэг, 4.1.15-р зүйл)
- ◆ **Хуулийн этгээд** гэдэг нь түүнийг бүрдүүлж буй хувь хүмүүсийн хуулийн статусаас ялгаатай хуулийн статустай нэгдмэл байгууллага юм. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа хуулиар зохицуулагдах бөгөөд тодорхой эрх эдэлж үүрэг хариуцлага хүлээнэ. Хүлээн зөвшөөрөгдсөн холбоод, хороод, хувь нийлүүлсэн хөрөнгөтэй компаниуд болон олон нийтийн байгууллагууд нь бүгд хуулийн этгээд юм.

6-р хайрцаг

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР

Монгол улсын газрын тухай хуулинд тусгай хэрэгцээний газарт дараахь газрууд хамаарна:

- ◆ Улсын тусгай хамгаалалттай газар
- ◆ Улсын хилийн зурвас газар
- ◆ Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар
- ◆ Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар
- ◆ Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт, байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай
- ◆ Аймаг дундын отрын бэлчээр
- ◆ Улсын тэжээлийн сангийн бэлчээрийн талбай
- ◆ Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай
- ◆ Газрын тосны гэрээт талбай
- ◆ Эдийн засгийн чөлөөт бүсийн газар
- ◆ Аймаг, сум, нийслэл Газрын тухай хуулийн дагуу өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно.
- ◆ Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас тусгай хэрэгцээнд авч болно.

Газрын тухай хууль, 16-р зүйлийн 1.1-3

олгогдсон талбайн булангийн цэг солбицлуудыг тэмдэглэх бөгөөд ут тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна. (19.8-19.9-р зүйл)

- ◆ Мэдэгдэл – Хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд АМГТХЭГ нь зөвшөөрлийн тухай мэдээллийг Байгаль орчны яам (БОЯ), холбогдох аймаг, сумын засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын газарт (МХГ) тус тус хүргэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. (19.10-р зүйл)
- ◆ Дахин тусгай зөвшөөрөл олгох – Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно. Мөн өмнө нь тусгай зөвшөөрөл олгогдоод тэр зөвшөөрөл нь цуцлагдсан талбайд сонгон шалгаруулалт явуулж хайгуул хийх тусгай зөвшөөрөл дахин олгоно. (19.12-20-р зүйл)

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө: Хариуцлага тооцох чухал боломж

АМТХ-ийн 6-р бүлгийн 38-р зүйлд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах ёстой гэж заасан байдаг. Угтаа зөвшөөрөл хүсэгч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хайгуулын зөвшөөрөл олгохоос өмнө боловсруулсан байхыг эрх бүхий төрийн байгууллага шаардах ёстой. Гэвч одоогийн хуулиар хайгуулын зөвшөөрөл авсан этгээд зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчныг хамгаалах

1-р зураг: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ерөнхий үйл явцад иргэд оролцох боломж



төлөвлөгөөг боловсруулсан байхыг шаардаж байна. Байгалийн нөхөн сэргээлт хийх, химийн хорт бодисын ашиглалтыг багасгах, зохистой ашиглах талаар төлөвлөгөөндөө тусгасан байх шаардлагатай байдаг. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг тухайн хайгуул явуулах сум, дүүргийн засаг даргад хүргүүлж батлуулсны дараа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлнэ. Засаг дарга төлөвлөгөө буюу түүний өөрчлөлтийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор хянаж, батлах шийдвэр гаргана.

Ашигт малтмалын тухай хуулийн энэхүү хэсэгт ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанд иргэд хэрхэн хяналт тавьж болох талаар тодорхой өгүүлсэн байдаг юм. АМТХ-ийн 38.1.8-д "Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тухайн сумын засаг даргын нээсэн тусгай дансанд хийнэ" гэж заасан

байдаг. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль хамгаалах төлөвлөгөөнд заасан ажлуудыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд засаг дарга тусгай дансанд хийсэн мөнгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах эрхтэй бөгөөд нэмэлт шаардлагатай зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч ямар ч маргаангүйгээр төлөх шаардлагатай. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын үйл ажиллагаанаас болж үүссэн байгаль орчны эвдрэлийг нөхөн сэргээж, төлөвлөгөөнд заасан бүх ажлыг хийж гүйцэтгэсэн тохиолдолд засаг дарга мөнгийг нь буцааж өгөх үүрэгтэй.

Эдгээр хуулийн заалтууд нь аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрөл орон нутагт, иргэдийн төлөө юу хийх санал бодолтой бөгөөд хэзээ хэрхэн орон нутгийн засаг захиргаа тусгай зөвшөөрөл олгох талаар тодруулж тодорхойлоход иргэдэд тус нэмэр болох арга замуудыг өгүүлсэн билээ. Иргэд нь уул уурхайн компани байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөгөө хэр сайн боловсруулж гаргасан болон тэр



төлөвлөгөө нь сайн хэрэгжсэн эсэхийг шалгах бололцоотой ба ингэхдээ доор дурьдсан хэд хэдэн асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй юм. Үүнд:

- ◆ Тусгай зөвшөөрөл олгогдсон газарт хайгуулын ажлаас буй болох үр дагаврыг байгаль хамгаалах төлөвлөгөөндөө тооцсон эсэх? Төлөвлөгөө хэр боловсронгуй, сайн байсан эсэх, эсвэл шаардлага хангахгүй байсан уу?
- ◆ Тусгай зөвшөөрөл хүсэгч компани байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөгөө сум, багийн холбогдох засаг даргад хүргэхээс өмнө орон нутгийн иргэдтэй уулзаж танилцуулсан эсэх. Хэрэв тийм бол хэнтэй зөвлөлдсөн болон иргэдийн санал бодлыг тусгасан эсэх.
- ◆ Компани байгаль хамгаалах шаардлагуудыг биелүүлсэн үү, эсвэл төрийн албан хаагчид биелэлтийг хангахад оролцох хэрэгтэй байсан уу?

2007 оны байдлаар Монгол улсын газар нутгийн 40 хувьд хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Хайгуулын үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд иргэд компани болон сум, дүүргийн засаг дарга нартай уулзаж ярилцснаар тухайн уул уурхайн компанийн мөн чанарыг мэдэж авч болно. Хайгуулын үйл ажиллагааны үеэр тухайн компанийн хандлага, байр сууриас уул уурхайн үйл ажиллагаа явагдвал орон нутгийнханд үр ашигтай байх уу, эсвэл хэцүү асуудал үүсгэх үү гэдэг нь ашиглаатын тусгай зөвшөөрөл олгогдохоос өмнө тодорхой болно.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талаарх мэдээллийг олж авах

Одоогийн мөрдөж буй тусгай зөвшөөрөл олгох журамд иргэд санал хүсэлтээ тусгах, оролцох боломжтой хугацаа нь

хязгаарлагдмал юм. 1-р зурагт үзүүлснээр тусгай зөвшөөрөл олгох үйл явцад иргэд ИТХ-аар дамжуулан оролцох, санал бодлоо илэрхийлэх боломжтой. ИТХ-

ын тэргүүлэгчид нь хуулийн дагуу, сонгогч иргэдтэйгээ байнгын холбоотой ажиллаж, иргэдээс дэвшүүлсэн өргөдөл, санал, гомдлыг төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг заасан хугацаанд аван иргэдэд хүргэх үрэгтэй. (Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 12.1.9-р зүйл)

ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчтэй хамтран ажиллахад бэлэн байх бөгөөд иргэд хамтран тулгамдсан асуудал, хэрэгцээг урьдчилан сайтар тодорхойлсон байх хэрэгтэй. Иргэд тодорхой үйл ажиллагаа юмуу эсвэл ашигт малтмааын тусгай зөвшөөрөл олгох үйл явцын талаар лавлан асуух гэж байгаагаа өөрсдийн сонгосон албан тушаалтнуудад мэдэгдэх ба тэднээс тусламж хүсч, орон нутгийн нөөцтэй холбоотой асуудал дээр тэдэнд туслах хүсэлтэй байгаагаа илэрхийлснээрээ төрийн албаны хүмүүстэй

найрсаг хамтын харилцааг бий болгож чадна. Ингэснээрээ төрийн албаны хүмүүс тухайн цаг үеийн мэдээллээр хангаж чадах холбоог бий болгоно.



Уул уурхайн бүх үйл ажиллагаа зардал, бас ашиг тусыг авчирдаг бөгөөд үр дүнд нь бий болсон нөлөөг засаж залруулах, нөхөн сэргээх, газар усаа хамгаалах, түүнчлэн тэрхүү үйл ажиллагаа нь иргэдийн хэрэгцээ шаардлага, ашиг сонирхолд хэрхэн нийцэж буйг тогтоох нь иргэдийн идэвх, чармайлтаас их шалтгаална.

Сумын засаг дарга, АМГТХЭГ гэх мэт төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд аливаа асуудлаа бичгээр дэвшүүлбэл үйл явц илүү үр дүнтэй болох ба иргэдээс дэвшүүлсэн асуудал болон төрийн эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хариултыг бичгээр үйлдэх ба ингэснээрээ албаны хүмүүс хууль ёсны дагуу мэдээлэл авахыг хүссэн хүсэлтэд

хэрхэн хариу өгч байгааг баримтжуулахад тус дөхөм болно.

Иргэд уул уурхайн үйл ажиллагаа болон тусгай зөвшөөрөлд хяналт тавих зорилгоор ИТХ-д оролцохын өмнө тодорхой асуултууд болон газруудад анхаарлаа хандуулах шаардлагатай. Үүнд:

◆ Тухайн тодорхой нутаг дэвсгэр дээр хайгуулын ажил явуулахыг хуулиар зөвшөөрсөн үү? Зөвшөөрөл авахаар төлөвлөсөн газар нь үндэсний цэцэрлэгт

хүрээлэн, байгалийн дархан цаазтай газар, тусгай хэрэгцээний газар, тахилгатай газар болон бусад дархан цаазтай газарт байгаа эсэхийг орон нутгийн байгаль орчны байцаагчаас асууж шалгах хэрэгтэй.

- ◆ Зөвшөөрөл хүсэгч нь АМГТХЭГ болон сум, дүүрэгт төлөх ёстой төлбөрөө хийсэн байна уу? Иргэд төлбөр төлөгдсөн эсэхийг мэдэх эрхтэй.
- ◆ Төрийн албан тушаалтан, зөвшөөрөл хүсэгч хоёр нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам, үе шатуудыг бүрэн дагаж мөрдсөн байна уу?
- ◆ Компани Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөндөө тусгасныхаа дагуу хайгуул хийх явцдаа байгаль орчныг хэрхэн хамгаалах вэ? Компанийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг орон нутгийн байгаль орчныг

хамгаалах төлөвлөгөөтэй харьцуулахад ямар байна вэ? Нэг нь нөгөөгөөсөө илүү байна уу? Хэрэв орон нутгийн төлөвлөгөө илүү байвал яагаад тийм байна вэ? Байгалийг зөв зохистой хамгаалахад компанийн төлөвлөгөөг хэрхэн сайжруулж болох вэ?

- ◆ Орон нутгийн иргэдийн асуудлуудийн талаар мэдэхийг хүсч уул уурхайн компаниас хэн нэг нь иргэдтэй зөвлөлдсөн үү? Тийм бол хэн хэзээ, хэнтэй зөвлөлдөж ярилцсан бэ? Ямар нэгэн шийдвэр гаргасан уу? Гаргасан бол тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай ярилцахдаа иргэдтэй зөвлөлдсөн зүйлсээ тусгасан уу?
- ◆ Компанийн өмнөх үйл ажиллагаатай холбоотой нэр хүнд нь ямар байна вэ? Ашигт малтмал олборлосон газартаа юу хийсэн бэ?



4

Ашиглалтын лиценз олгох үйл явцад иргэдийг оролцуулах арга зам



Хайгуулын үр дүнд эдийн засгийн хувьд ашигтай байх ашигт малтмал, төмөрлөг, барилгын материал олж илрүүлсэн тохиолдолд компани нь ашигт малтмал олборлохын тулд **ашиглалтын тусгай зөвшөөрлийг** авах шаардлагатай. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох явцын эхний шатанд иргэд оролцож, тусгай зөвшөөрөл олгох эсэх талаарх шийдвэрт өөрсдийн саналыг тусгах боломжтой. Иргэдийн оролцоо, хяналт тавих үндсэн эрхүүдийг Ашигт малтмалын тухай хууль (4-р бүлэг, 24-26-р зүйл), Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2-р бүлэг, 7-р зүйл; 3-р бүлэг, 18.1.2-р зүйл), Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудад (1-р бүлэг, 4.8-р зүйл) тодорхой зааж өгсөн байдаг.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлдөө **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг** (БОНБУ) хавсаргасан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл АМГТХЭГ-т өргөдөл гаргахаасаа өмнө БОНБУ-г тусгай зөвшөөрөл хүсэгч компани хийлгэсэн байх ёстой юм.

Хуулиар БОНБУ хийх явцаа орон нутгийн иргэдийг оролцуулахыг албан ёсоор шаарддаг учраас компани ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэн БОНБУ хийлгэж байгаа болон түүнд оролцох ёстой гэдгээ иргэд мэддэг байх шаардлагатай юм. Иргэд өөрийн орон нутагт юу болж байгааг мэдэж байх хэрэгтэй ба хэрэв мэдэхгүй бол оролцох боломжоо алдана. Хэн хайгуулын тусгай зөвшөөрөл авсныг мэдэж, үйл ажиллагаанд нь хяналт тавих нь хамгийн сайн арга юм.

2-р зурагт ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад иргэд хэрхэн, ямар журмаар оролцох боломжийг харуулав.

2-р сүраг: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох ерөнхий үйл явцад иргэд оролцох боломж



Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Ашигт малтмалын тухай хуулийн 4-р бүлэгт ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг олгох үе шатыг тусгаж өгсөн байдаг. Үүнд:

1. Өргөдөл гаргах – Хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд ашигт малтмал ашиглахыг хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу АМГТХЭГ-т гаргах ба өргөдөлд доорх зүйлсийг хавсаргана. (24-25-р зүйл) Үүнд:

- ◆ Талбай нь тал бүр тийш 500 метрээс багагүй урттай, уртраг өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн тэгш олон өнцөгт хэлбэртэй байна.
- ◆ Үйл ажиллагаа явуулах талбайн орших аймаг, сум, хот болон дүүргийн нэрийг бичсэн газрын зураг
- ◆ Өргөдөл гаргагчийн нэр, хаяг, утас,

электрон шуудангийн хаяг, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны нэрийг тусгасан тодорхойлолт

- ◆ Өргөдөл гаргагч нь татвар төлөгч хуулийн этгээд мөн эсэхийг нотлох баримт
- ◆ АМТХ-ийн дагуу хийгдсэн талбайн зураг ба зураг дээр байрлах аймаг, сум, дүүргийн нэрс
- ◆ Үйлчилгээний хөлс төлсөн баримтууд
- ◆ Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын шийдвэр
- ◆ Хайгуулын ажлын явцад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт
- ◆ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.

2. Өргөдлийг хянаж үзэх – АМГТХЭГ ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээж авсны дараа өргөдөл болон хавсралт бичиг баримтуудыг

бүртгэх, мөн тэдгээр бичиг баримтууд хуулинд заагдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж, тухайн талбай уурхайн зориулалтаар ашиглах боломжтой эсэх, хайгуул хийж болох талбайн тогтоосон хязгаар дотор байгаа эсэхийг нягтлах ба зарим шаардлагатай тодруулгуудыг хийнэ. (26.1-26.2-р зүйл)

3. Эцсийн шийдвэр – АМГТХЭГ нь өргөдлийг бүртгэнсээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэр гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан, хуулийн үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ. (26.3-р зүйл)

4. Тусгай зөвшөөрөл хүлээн авагч төлбөр төлөх – Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан этгээд мэдэгдэл авсан өдрөөс хойш 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө. (26.4-р зүйл)

5. Тусгай зөвшөөрөл олгох – Өргөдөл гаргасан этгээд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг хуулийн дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгож, тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ. (26.5-26.6-р зүйл)

6. Мэдэгдэл – Ашигт малтмалын тухай хуулийн 26.7-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны байгууллага нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 7 хоногийн дотор багтааж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллага, тухайн зөвшөөрлөөр олгогдсон талбай орших аймаг, сум, дүүргийн засаг дарга, мэргэжлийн хяналтын газарт энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. (26.7-р зүйл)

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон талбайд ашиглалтын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно. (26.9-р зүйл)

Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход иргэдийн оролцоо: Уул уурхайн компаниуд өргөдлөө гаргахаас өмнө иргэд оролцох боломж нээлттэй байдаг

Бүх уурхайн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн зардал шаарддаг ч эргээд ашиг орлогыг бий болгодог. Уул уурхайн компаниуд орон нутгийн иргэдийн ашиг сонирхолд үйл ажиллагаагаа хэрхэн нийцүүлэн явуулах болон газар, усыг хамгаалах эсэх нь иргэдийн зориг шийдэмгий байдлаас шалтгаална. Зарим компани уул уурхайн үйл ажиллагаа явуулахдаа тухайн орон нутгийн иргэдээс “олон нийтийн зөвшөөрөл” авах хэрэгтэй гэж үзэж байхад зарим нь тэгдэггүй. Уул уурхайн компаниуд хэр зэрэг нэр хүндтэй талаар мэдэх нь туйлын чухал байдаг. Ер нь хариуцлагатай уул уурхай нь орон нутгийн иргэдийн сайн сайхны төлөө чиглэсэн, сайн зохион байгуулалттай үйл ажиллагаан дээр тулгуурладаг. Олон компани хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг явуулахыг хүлээн зөвшөөрдөг ба иргэд хяналт тавьж, үйл ажиллагаагаа

сайн явуулахад нь компанийг шахаж өгдөг ба ер нь иргэд асуудалд анхаарлаа нухацтай хандуулснаар ашигтай үр дүнд хүрдэг. Тийм учраас явагдахаар төлөвлөгдөж байгаа уул уурхайн үйл ажиллагаанд ямар нэг хэмжээгээр нөлөө үзүүлэхийг хүсч байгаа иргэд олон нийтийн хурал болон иргэдийн нөхөрлөлөөр дамжуулан оролцож болох юм. Байгальд нөлөөлөх байдлын үнэлгээг явуулах шатанд иргэд санал бодлоо илэрхийлэх боломжтой.

Ашигт малтмалын хуулийн 25.1.7-д зааснаар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хавсаргасан байх шаардлагатай. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн 5.4.8-д заасны дагуу "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дэлгэрэнгүй тайланд тухайн нутгийн ашигт малтмалыг ашиглахыг хүссэн хуулийн этгээд тухайн нутгийн иргэд, сум, дүүргийн ИТХ-ын саналыг тусгах шаардлагатай байдаг." Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл явцад иргэд санал бодлоо илэрхийлснээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт иргэд оролцож байгаа болно.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгохоос өмнө иргэд БОНБУ-ний явцад тухайн орон нутгийн иргэд санал бодлоо илэрхийлэх ба эдгээр санал бодлоо олон нийтийн тайлан мэдээнд оруулахын тулд иргэд олон нийтийн хурал цуглааны тэмдэглэлийг үнэн зөв хөтөлж, хурал цуглааны фото зураг юмуу видео бичлэг гэх мэт баримт материалыг бүрдүүлэх хэрэгтэй ба мөн хэвлэл мэдээллийнхнийг урьж оролцуулж болно.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад шаардагдах байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээн дээр өгөх саналаа боловсруулж гаргахдаа нутгийн иргэд доорх зарим чухал

асуудлуудад анхаарлаа хандуулснаар үр дүнд хүрнэ. Үүнд:

- ◆ Компани хайгуулын хууль ёсны тусгай зөвшөөрөлтэй байна уу? Зөвшөөрөл олгох үйл явц Ашигт малтмалын тухай хуулинд заагдсан үе шатуудын дагуу явагдсан уу? Өргөдөл гаргагч нь хууль ёсны хайгуулын тусгай зөвшөөрөлтэй байна уу, үгүй юү гэдгийг сумын засаг даргаас шалга. Хэрэв компани хууль ёсны хайгуулын тусгай зөвшөөрөлгүй бол яагаад гэдгийг нь тодруул. Засгийн газраас энэ талаар ямар нэг арга хэмжээ авсан уу?
- ◆ Хайгуул хийж ашигт малтмал, төмөрлөг болон барилгын материалын ямар нөөцийг олж иарүүлсэн бэ? Эдгээр нөөц баялагийг олборлосноор эдийн засгийн хувьд хэр их ашиг олох вэ? Иргэд баримжаагаар тооцоолсноор тухайн нөөцөөс гарах үр ашгийг мөн ойролцоогоор тогтоох боломжтой болно. Мөн Ашигт малтмалын тухай хуулинд тусгай зөвшөөрөл авсан компани нь ашигт малтмалын нөөцийг бүрэн гүйцэд олборлох ёстой гэж заасан ба нөөц ихтэй хэсэг газраас сорчилж олборлохыг хориглосон байдаг.
- ◆ Уул уурхайн үйл ажиллагаа нь байгаль орчинд ямар сөрөг нөлөө үзүүлж байна вэ? Хаана уурхайн үйл ажиллагааг явуулах вэ? Үйл ажиллагаа явуулах хэсэгт ховордсон, устах аюулд орсон болон орж болзошгүй зүйлүүд гэх мэт экологийн хувьд чухал талбай байна уу? Уул уурхайн компани байгаль орчны урт хугацааны нөлөөллийг хэрхэн шийдвэрлэх вэ? Уурхай нь уул уурхайн олон улсын шилдэг арга туршлагад нийцсэн техникийг ашиглаж байна уу? Компани нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөг багасгах юмуу арилгах арга

замуудын талаар анхааралдаа авч ажиллаж байна уу?

- ◆ Уул уурхайн компани нь үйл ажиллагаагаа явуулж байгаа бусад газруудаа байгаль орчинд үзүүлж байгаа нөлөө болон нийгмийн бэрхшээлтэй асуудлуудыг багасгах, шийдвэрлэх юу хийж байна вэ? Уул уурхайн олон компани нэгээс илүү газарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өөр бусад газруудад явуулж байгаа

үйл ажиллагааг нь судалснаар уг компани нь орон нутгийн иргэд, байгаль орчинд хэрхэн ханддаг болохыг нь мэдэж болно. Мөн хайгуулын үе шатанд

компани хэрхэн байгаль орчинтой холбоотой шаардлагуудыг биелүүлж байгааг иргэд ажиглаж болно.

- ◆ Компанийн санхүүгийн боломж нь ямар байна вэ? Уул уурхайн үйл ажиллагааг бүхэлд нь амжилттай явуулах хэмжээний хөрөнгөтэй байна уу? Уул уурхайн үйл ажиллагаа нь байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь эдийн засгийн үр ашгаас хэт их байвал компанид хүндрэл учрах төдийгүй ирээдүйд орон нутгийн иргэдэд муутгаар нөлөөлнө. Компани ойрын үед болон ирээдүйд гарах асуудал, сөрөг нөлөөг багасгах санхүүгийн чадвартай байна уу? Компани нь сум болон дүүргийн тусгай дансанд шаардлагатай хэмжээний төлбөрийг



Орон нутгийн иргэд байгаль орчны үнэлгээ хийгдэх явцад өөрийн санал бодлоо оруулах нь ашигласнын лиценз олгох шийдвэрт оролцож байгаа хэрэг юм.

хийсэн үү? Сумын, дүүргийн засаг дарга АМТХ-ийн 38-р зүйлд заасны дагуу бий болсон хөрөнгийг ашиглах шаардлага гарч байна уу?

- ◆ Үйл ажиллагаа нь орчин үеийнх байж чадаж байна уу? Санхүүгийн боломж муутгаас шалтаалан хоцрогдсон техник технологи ашигласнаар маш их үнэ цэнэтэй бүтээгдэхүүнийг (алт гэх мэт) газарт үлдээдэг ба үүнээс болж тухайн газар дахин олборлолт хийх, байгалийг

нөхөн сэргээх үйл ажиллагааг хийхгүй орхих, зарим тохиолдолд уурхайн хаягдал дээр хууль бус (нинжа нар ажилаах гэх мэт) олборлолт хийх зэрэг сөрөг нөлөөг бий болгодог.

- ◆ Уул уурхайн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн иргэд үр ашиг хүртэх үү? Хүртэх бол хэрхэн хүртэх вэ? Уул уурхайн компани орон нутгийн иргэдийг авч ажиллуулах уу? Уул уурхайн компани ямар ямар баталгаа өгч чадах вэ? Уул уурхай нь аймаг, сумд нийгэм, эдийн засгийн ямар үр ашгийг авчрах вэ? Орон нутгийн нөөц баялагийг олборлохоор төлөвлөсөн уул уурхайн

компани хариуцлагатай уул уурхайг үзүүлэн хэрэгжүүлэх боломжтой билээ. Хариуцлагатай уул уурхай гэдэг нь эдийн засгийн ашиг орлогыг орон нутагт хүртэх боломжийг бий болгодог учраас орон нутгийн иргэд сургууль, эрүүл мэндийн үйлчилгээ, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж, засварын ажилд туслуулах, интернэтэд

холбуулах болон бусад эдийн засгийн хөгжилд ашиг тусаа өгөх зүйлс дээр туслуулах хүсэлт гаргаж болно.

болон сумын хаана хаана эдгээр тусгай зориулалттай газрууд байгаа талаарх мэдээллийг авч болно.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох талаарх мэдээлэл олж авах



Байгаль орчны яаманд Монгол улсын усны чанар, газар ашиглалт болон бусад байгаль орчны асуудлуудтай холбоотой мэдээлэл хадгалагдаж байдаг ба уг яамны ажилтнуудын

тусламжтайгаар усны эх, гол болон амьд байгальд үзүүлж байгаа нөлөөг тогтоон үнэлгээ дүгнэлт өгч болно.

Уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглосон байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар; байгаль түүхийн хөшөө, дурсгалт зүйлстэй газрын талаарх мэдээллийг Байгаль орчны яам, Гео-Экологийн хүрээлэн; Геологи, уул уурхайн кадастрын алба болон гадаад, дотоодын төрийн бус байгууллагуудаас авч болно.

Улсын мэргэжлийн хяналтын газарт үйлдвэрлэлийн зөрчилтэй холбоотой мэдээлэл хадгалагддаг бөгөөд байцаагчид компаниудын талаар судлахад нь иргэдэд тусална.

Засгийн газар жил бүр Улсын Их Хурлын хаврын чуулганаар төр, байгаль орчны нөхцөл байдлын талаар тайлагнадаг ба сумын засаг дарга нар 11-р сарын 15 гэхэд мэдээллийн сангийн тайланг гаргаж, 12-р сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн засаг даргад тайлагнадаг. Аймаг, нийслэлийн засаг дарга нар тайлангаа жил бүр 12-р сарын 31-ний дотор төрийн захиргааны төв байгууллагуудад танилцуулдаг. Тайланд доорх зүйлийг оруулсан байна. Үүнд:

- ◆ Байгалийн баялагийг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан улсын төсвийн ба төсвийн бус хөрөнгийн зарцуулалт

Иргэд байгаль, хүрээлэн буй орчин болон уул уурхайн талаарх мэдээллийг олон эх сурвалжаас олж авч болох ба энэхүү хэсэгт уул уурхайн талаарх хангалттай мэдээллийг хаанаас авч болохыг жагсаан үзүүлэв. Хавсралт 2-оос доор дурдсан байгууллагуудын хаяг, холбоо барих утасны дугаар зэргийг үзэж болно.

Багийн иргэдийн нийтийн хурал жилд дор хаяж гурван удаа хуралдах ёстой бөгөөд энэ талаар хуулинд заасан байдаг. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг иргэдийн хурлын тэргүүлэгчдээс (багийн засаг дарга гэх мэт) авч болох ба мөн тэдэнд асуудлаа бичгээр дэвшүүлж болно.

Иргэдийн нөхөрлөл нь уул уурхай, уул уурхайтай холбоотой асуудлын талаар мэдээлэл авах болон санал оруулж, асуудлыг бичгээр дэвшүүлэхэд нь иргэдэд тусална.

Сумын засаг даргын тамгын газарт уул уурхайн талаарх мэдээлэл хадгалагдаж байдаг ба уг мэдээллийг иргэд авч, ярицан сонирхсон асуултаа хариулт авч болно. Мөн иргэд тамгын газрын байгаль орчныг хариуцсан байцаагчаас ямар үйл ажиллагааг тусгай зориулалттай газар нутагт явуулахыг зөвшөөрдөг ямар үйл ажиллагааг явуулахыг хориглодог тухай

- ◆ Байгалийн баялагийн нөөцөд гарсан өөрчлөлт, чиг хандлага
- ◆ Байгалийн баялагийн нөөцийн ашиглалт болон тэдгээрийн нөхөн сэргээлт
- ◆ Орчны бохирдлын эх үүсвэр, түвшин, түүнийг бууруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн (Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 12.9.1-12.9.4)

ИТХ-ын гишүүд засаг даргын байгаль орчныг хамгаалах ажлын тайланг хүлээн авч танилцах эрхтэй. (Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 18.1.3-р зүйл)

Иргэд доорх зүйлсийн талаарх ИТХ-ын тэргүүлэгчдийн тайланг сонсох эрхтэй. Үүнд:

- ◆ Байгаль орчныг зүй зохистой ашиглах төлөвлөгөө, нутаг дэвсгэр дээрх байгалийн нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн зарцуулалт
- ◆ Засаг даргын байгаль хамгаалах ажлын тайлан

Иргэд аймаг, сумын засаг дарга нар, эсвэл ИТХ-ын тэргүүлэгчид иргэдээс санал бодлыг нь хүлээн авсан эсэх дээр хяналт тавих эрхтэй. Иргэд санал бодлоо илэрхийлж байх хугацаандаа мөн албан тушаалтнууд авлигын хэрэгт (хээл хахууль авах гэх мэт) ямар нэг хэмжээгээр оролцож байгаа эсэхийг судлахыг хүсч болох юм.

Иргэд, иргэдийн нөхөрлөл нь олгогдсон, олгох гэж байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талаарх мэдээллийг АМГТХЭГ-ын Геологи, уул уурхайн кадастрын албанаас авч болно.

Байгаль хамгаалах тал дээр үйл ажиллагаа явуулдаг иргэдийн нөхөрлөл болон бусад сайн дурын байгууллагууд нь:

- ◆ Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтэнд олон нийтийн хяналт тавиулах, гарсан зөрчлийг арилгахыг шаардах, эрх бүхий байгууллагуудад асуудал дэвшүүлэн шийдвэрлүүлэх,
- ◆ Байгаль орчныг хамгаалах асуудлаар



Төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох хурал, засаг даргад санал дэвшүүлж болно.

Төрийн захиргааны болон иргэний нийгмийн байгууллагаас ашигт малтмалын ашиггаалтын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг олж авахад Авлигын эсрэг хуулийн 6.1.2-р зүйлийг үндэс болгож болно. Уг заалтад “Тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нийтэд нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор

харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх нь төрийн байгууллагын үүрэг” гэж заажээ. Иргэд энэхүү заалтыг үндэс болгон байгаль орчны талаарх мэдээллийг авч болно.

Ашигт малтмалын тухай хуулийн 57.4-т “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаарх мэдээллийг байгаль орчны болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ” гэж заажээ.



5

Эерэг үр дүнгийн төлөө ажиллах



Иргэдийн оролцоо нь сайн засаглалын баталгаа бөгөөд тогтвортой ардчиллын үндэс болж өгдөг. Иргэдийн эерэг, мэдээлэл сайтай оролцоо нь харилцан хоёр талын хүсэл сонирхолд нийцсэн үр дүн, үр ашгийг бий болгож, асуудлыг “хамтдаа ялах” (win-win) аргаар шийдвэрлэж чадна. Талуудын байр суурийг бус ашиг сонирхлыг ойлгож мэдэх нь энэ үйл явцад их чухал юм. Жишээлбэл, 2-р бүлэгт иргэд компаниас өөрсдийг нь үйл ажиллагаандаа оролцуулж, орон нутгийнхныг ажлын байраар хангаж, газрыг нь нөхөн сэргээхийг хүсдэг болохыг өгүүлсэн билээ. Эдгээр нь зөв, бодит үндэслэлтэй хүсэлт бөгөөд эдгээр хүсэлт нь компаниудад ойлгомжтой юм. Олон нийт, хувийн хэвшил болон иргэний нийгэмлэг гэх мэт холбогдох оролцогч талууд өөрсдийн байр суурь, ашиг сонирхлоо илэрхийлэхийн тулд эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллийг гаргаж ирэх ёстой. Уул уурхайгаас компанид орох ашиг орлого ба засгийн газарт орох ашиг (төлбөр, татвар, нөөц ашигласны төлбөр) хэр их байх, хэрхэн хувиарлах талаар мэдээлэлтэй байх нь эрсдэл ба ашгийг шударгаар хуваарилах асуудлын үндэс мөн. Усны чанар, хэмжээний гэх шинжлэх ухааны мэдээлэлтэй байх нь уул уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө байгаль орчны ямар асуудал байх ба хэрхэн хамгаалах тухай хэлэлцэхэд чухал бөгөөд гарч болохуйц нөлөөг тогтооход суурь үндэс болно. Талуудын ашиг сонирхол болон туршлага дээр үндэслэсэн үнэн, зөв мэдээллийг ойлгож мэдсэнээр “хамтдаа ялах” аргаар асуудлыг шийдвэрлэх боломжтой байдаг.

Гэхдээ зөрчилдөөн, үл ойлголцол гарсан тохиолдолд яах вэ? Маргаан зөрчилдөөн гарвал асуудлыг хурлын танхимд тайван замаар ярилцаж шийдэхээс авахуулаад шүүхээр шийдэх хүртэл ширүүн арга замууд байдаг. Тайван замаар шийдэх үү, шүүхээр шийдэх үү гэдэг нь үйл ажиллагаа эхлэхээс өмнө талуудын дээр дурдсан зүйс дээр хийсэн яриа хэлэлцээр, тохиролцооноос шалтгаална. Талуудын харицаа

бүр эхнээсээ бие биеэ хүндэтгэсэн чиг хандлагатай байвал маш олон тооны эерэг үр дүнг араасаа дагуулна. Эсрэг тохиолдолд, бие биеэснээсээ харилцан хүндэтгэхгүй байх нөхцөлд шүүхээр асуудлаа шийдүүлэх хэрэг гарах ба ингэснээр цаг их зарсан, зардал ихтэй, уур уцаар барсан, шүүхийн шийдвэр ямар гарах нь тодорхойгүй тийм аюултай нөхцөл байдалд хүрч болно.

Жишээ: Төв аймгийн Тосон Заамар – Туул гол хөдөлгөөний оролцоо. Аймаг, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор тусгай хэрэгцээний

газраас тодорхой газруудыг чөлөөлөн тусгай зөвшөөрөл авахад дэмжсэн санал өгч хайгуулын 5-н тусгай зөвшөөрөл өгсөн байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 14.2 заалт, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2, 19.2 зэрэг заалтуудыг зөрчсөн хууль бус шийдвэр болсон байна. Тосон Заамар–Туул гол хөдөлгөөн нь 2007 оны эхээр энэхүү хууль бус шийдвэрийг болон тусгай хамгаалаалтай газар тусгай зөвшөөрлийг эсэргүүцсэн арга хэмжээ авсаны үр дүнд хууль бус тусгай зөвшөөрлийг цуцлуулахаар тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийг Нийслэлийн захиргааны шүүхэд өгсөн бөгөөд одоо шийдэгдэх шатандаа явж байна. Үүнээс гадна ИТХ-ын ээлжит бус хурлыг хуралдуулснаар Тосон Заамар–Туул гол хөдөлгөөн баг, сумын засаг дарга нартай хамтарч ажиллан Тосон Заамар



сумын “Хөгжлийн сан”-гаас хөдөлгөөний “Ногоон төгөл” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлүүлэхэд санхүүгийн дэмжлэг туслаацаа авч чадсан байна. Уг сангийн хөрөнгийг орон нутагт үйл ажиллагаа явуудаг аж ахуйн нэгжүүд тэр дундаа уул уурхайн компаниуд бүрдүүлдэг болно. Мөн 2007 оны 8-р сард “Уул уурхайн салбар дахь

байгаль орчны нөхөн сэргээлт” сургалтын үйл ажиллагааг Улсын мэргэжлийн хяналтын газар болон Үйлдвэр худалдааны яам, Монполимет ХХК, Алтан Дорнод–Монгол ХХК компаниудтай хамтран зохион байгуулсан

билээ. Уг арга хэмжээнд орон нутгийн болон улсын хэмжээний төрийн албан тушаалтнууд, уул уурхайн компанийн мэргэжилтнүүд, жирийн ажилтнууд болон иргэдийн төлөөлөгчид оролцсон. Тосон Заамар – Туул гол хөдөлгөөний тэргүүн Д. Энхтөр “Ногоон төгөл” нөхөн сэргээлтийн цогц хөтөлбөрөө олон нийтэд амжилттай танилцуулж чадсан байна. Хамтарч ажиллан, үнэн зөв мэдээлэл олж, эдгээр ажлыг үр дүнтэй гүйцэтгэхийг зорьсноороо Тосон Заамарт “хамтдаа ялах” аргыг урт удаан хугацаанд авч хэрэглэх үндэс суурийг тавьсан байна.

7-р хайрцагт алтны компани оролцсон хэргийг хэрхэн шүүхийн аргаар шийдвэрлэсэн жишээг үзүүлэв. Үйл явц удаан байсан ч үнэн ялсан юм.

Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ардчилсан замаар шийдвэрлэхэд иргэд нь нийтийн хурыг зохион байгуулж оролцох, өөрсдийн нэр

дэвшүүлж сонгосон албан тушаалтнуудаа хариуцлага тооцох шаардлагатай байдаг. Асуудлыг хууль ёсоор, шүүхийн аргаар шийдэх нь боломжтой арга хэмжээ боловч иргэдийн сайн дурын идэвхитэй оролцооны стратеги илүү эерэг үр дүнд хүрдэг. Компаниуд болон албан тушаалтнууд хүмүүсийн нийтлэг ашиг сонирхолд нийцэх шийдвэрийг гаргах боломжийг эрж хайснаар нөхцөл байдал буруугаар эргэж, ширүүн маргаан бий болохоос өмнө оролцогч талууд “хамтдаа ялах” аргаар асуудлыг шийдэх боломжтой болно.

Иргэдийн энэ хэлбэрийн оролцоог хангахдаа бие биенийхээ үгийг сонсож, бие биенээсээ суралцаж, гол нь бие биенийхээ ялгаатай зүйлст анхаарлаа хандуулах биш, үүссэн асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай байдаг. Энэ нь хүмүүсийн хувийн зан чанарыг харахаасаа илүү асуудлын голыг хар гэсэн үг юм. 2-р бүлэгт өгүүлсэнчлэн иргэд өөрсдөө дотроо зохион байгуулалт хийж орон нутгийнхаа ашиг сонирхол юу болохыг судлан мэдэж, орон нутгийнхны ашиг сонирхлыг илэрхийлсэн саналыг уурхайн төлөвлөгөө боловсруулж буй хүмүүст илэрхийлж чадах хүнийг олох хэрэгтэй юм.

Үүссэн маргааныг шийдвэрлэх

Иргэд уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавьж, оролцох явцад олон янзын маргаан, зөрчил үүсч болно. Жишээлбэл, иргэний болон төрийн байгууллагуудын хооронд, иргэн болон уул уурхайн компанийн хооронд, иргэдийн нөхөрлөлийн дотоодод, нөхөрлөл хооронд, нөхөрлөл болон уул уурхайн компанийн хооронд гэх мэтээр маргаан, зөрчилдөөн гардаг ба гарсан

7-р хайрцаг: Сумын ИТХ-ын алт олборлохыг зөвшөөрсөн тогтоол болон сумын засаг даргын газар, ус ашиглах талаар гаргасан шийдвэрийг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон тухай

Архангай аймгийн Цэнхэр сумын иргэн, Ариун Суварга хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж Архангай аймгийн Цэнхэр сумын Цэцэрлэг багийн Нарийн хамар хэмээх газарт алт олборлохыг зөвшөөрсөн Цэнхэр сумын засаг даргын захирамжийг эс зөвшөөрч, Архангай аймгийн шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Нэхэмжлэл гаргах үндэслэл: Тус нутагт алт олборлох үйл ажиллагаа нь сөрөг нөлөөтэй болохыг баталсан. Гео-Экологийн хүрээлэнгийн эрдэмтдийн дүгнэлт гарсан. Иргэд Цэнхэр сумын ИТХ-ын Тэргүүлэгчийн 2005 оны 7-р сарын 1-ний өдрийн тогтоолд үндэслэн Нарийн Хамарын 68 га газарт олгосон зөвшөөрлийг хүчингүй болгохыг шаардсан. Өмнө нь Нарийн Хамарын голын сав газрыг тусгай хамгаалалтанд авч алт олборлох үйл ажиллагаа явуулахыг хориглосон тогтоолыг Цэнхэр сумын ИТХ-аас 2005 оны 3-р сарын 5, мөн оны 6-р сарын 13-ны өдөр тус тус гаргасан байна.

Архангай аймгийн шүүх хэргийг судалж үзэн, Цэнхэр сумын алтны олборлолтын талаар ИТХ-ын тэргүүлэгчдийн гаргасан шийдвэр нь ямар ч үндэслэлгүй болохыг баталсан иргэдийн нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрч, Цэнхэр сумын засаг даргын гаргасан газар, ус ашиглуулах захирамжийг хүчингүйд тооцсон байна.

Уг хэргийг шийдвэрлэхдээ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1.3 болон 10.1-р зүйл, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11.1.1, 11.2 болон 25.3-р зүйлүүдийг гол үндэслэл болгосон байна.

Эх сурвалж: Архангай аймгийн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, дугаар 04, Цэцэрлэг баг, 2006 он

маргаан зөрчилдөөнийг шүүхээр, хуулийн дагуу юмуу эсвэл шүүхийн системээс гадуур өөр бусад арга замаар шийдвэрлэж болно. Ихэнхдээ маргааныг *тохиролцоонд хүрэх замаар, заримдаа гуравдагч этгээдийн тусламжтайгаар шийдвэрлэх* нь маргалдагч талуудад илүү үр нөлөөтэй, нааштай үр дүнтэй байдаг.

Маргаан үүсч эхлэх үед маргааныг тохиролцооны аргаар бус, хууль ёсны дагуу шүүхээр шийдвэрлүүлэхэд хэр их зардал, хугацаа шаардагдахыг тооцоолж үзэх хэрэгтэй. Шүүхээр шийдүүлбэл цаг хугацаа, зардал мөнгө их шаардагдахаас гадна шүүхийн шийдвэр бодож байснаас өөр гарч болно. Шүүхээс гадуур маргаанаа шийдвэрлэсэн тохиолдолд зардал бага гарна.

Зөвшилцлийн үндсэн дээр гаргах тохиролцоо нь оролцогч талуудын тавьж байгаа хатуу шаардлага дээр үндэслэсэн байр сууриа хадгалсан юмуу эсвэл талууд хэн хэнийхээ үндсэн хэрэгцээ шаардлагыг (сонирхол гэх мэт) илүү гүнзгий судалсан, ашиг сонирхол дээр үндэслэсэн байж болно.

Доорх зүйлс дээр анхаарлаа хандуулснаар тохиролцоо амжилттай, үр дүнтэй болно:

- ◆ Тохиролцооны нөхцлүүдийг (үйл явц) тодорхой гарга.
- ◆ Бие бие анхааралтай сонсож, зөв ойлгож, итгэлцэл бий болго.
- ◆ Гол асуудал болон оролцож байгаа талуудын сэтгэлийг зовоож байгаа зүйлүүдийг тодорхой болго.
- ◆ Маргаан үүсгэж буй асуудлууд дээр анхаарлаа бүрэн хандуул (Хүн рүү бус, асуудал руу ханд).
- ◆ Талуудын ашиг сонирхолд нийцсэн үр ашигтай шийдвэр гаргахыг хичээ.

Доорх үе шатуудаар талуудын хоорондох ялгааг арилгаж болно:

- ◆ Маргааныг асуудал гэсэн үүднээс биш бие биенээсээ сурах, хөгжих боломж гэсэн үүднээс хар.
- ◆ Эсрэг талынхаа хүсэл, ашиг сонирхлыг ойлгож мэд.
- ◆ Шаардлагатай мэдээллийг цуглуул.
- ◆ Бие биенийхээ үгийг анхааралтай сонс. Анхааралтай сонссоноор маргалдаж буй бусад талуудтай харилцах харилцаа тань сайжирна.
- ◆ Эсрэг талынхаа сөрөг хандлагыг өөрчлөхийн тулд “Би”, “Миний” гэсэн ойголт дээр бус, нийтлэг ашиг сонирхолд анхаарлаа хандуул.
- ◆ Сэтгэлийн хөөрлөөр шийдвэр бүү гарга.
- ◆ Дайралт, гүтгэлгийг өнгөрөөж сур.

Гуравдагч этгээдийн оролцоо

Заримдаа талууд дундыг баримталсан гуравдагч этгээдийн туслаацаа дэмжлэгтэйгээр үр ашигтай тохиролцоонд хүрч чаддаг. Гуравдагч этгээд шийдвэр гаргах үйл явцыг чиглүүлж өгдөг ба доорх зүйлсийг хийж гүйцэтгэдэг. Үүнд:

- ◆ Маргаанд оролцогч бүх талуудад дэмжлэг үзүүлэх ба асуудлыг бүгдэд ашигтайгаар шийдвэрлэдэг.
- ◆ Маргалдагч талуудыг хоорондоо зөвшилцөж, асуудлыг эе эвээр шийдвэрлэхийг уриалдаг.
- ◆ Маргалдагч талуудын санал бодол, хүсэлтийг сонсож, талууд бие биенийхээ хэрэгцээ, шаардлагыг зөв ойлгосон эсэхийг магадлана.
- ◆ Дайралт, доромжлол, буруушаалт, сүрдүүлгийг зөөлрүүлж, хүмүүсийн анхаарлыг харилцан буулт хийх тал руу хандуулна.

Зөвшилцөл, тохиролцоо нь доорх дараалаар явагддаг. Үүнд:

- ◆ Зөвшилцөж, тохиролцоонд хүрэх үндсэн дүрэм журмыг талууд тохиролцох
- ◆ Асуудлыг тодорхойлж, танилцуулах
- ◆ Талуудын хэлэх үгийг сонсох
- ◆ Асуудлын учир шалтгааныг судлах (Хүн рүү бус, асуудал руу хандах ёстойг бүү март.)
- ◆ Эндүү ташаа ойлголт байвал засч залруулах
- ◆ Маргаан үүсгэж буй бүх асуудлыг авч хэлэлцсэн эсэхээ магадлах
- ◆ Маргалдагч талууд бие биенийхээ ашиг сонирхлыг (эсвэл байр суурийг) ойлгохыг хичээх
- ◆ Аль аль талынхаа ашиг сонирхолд нийцсэн үр дүнг бий болгох арга замуудыг тодорхойлох
- ◆ Маргалдагч талууд бие биеэ хүндэтгэсэн байр сууринаас асуудлыг шийдвэрлэхийг хичээх
- ◆ Талуудын сэтгэлд бүрэн дүүрэн нийцсэн ямар шийдвэр байж болохыг тодорхойлох
- ◆ Эсрэг талаа ялан дийлэх гэж оролдохын оронд бие биенийхээ ашиг сонирхолд хэрхэн нийцүүлэх тал дээр анхаарлаа хандуулах
- ◆ Бүх талуудад ашигтай байхаар асуудлыг шийдвэрлэх арга замын талаар талууд тохиролцох
- ◆ Тохиролцоо нь маш тодорхой, дэлгэрэнгүй байх
- ◆ Тохиролцоог баримтжуулах
- ◆ Дүгнэлт хийж маргааныг дуусгавар болгох

ДҮГНЭЛТ

Шүүхээр асуудлыг шийдвэрлүүлснээс өөрсдөө хамтарч асуудлыг шийдвэрлэсэн нь илүү үр дүнтэй байдаг бөгөөд асуудлыг шийдвэрлэх энэ арга нь хүмүүсийг хүссэн үр дүнд нь хүргэх анхны алхам байх ёстой. Асуудлыг шүүхээр аль болох шийдвэрлүүлэхгүй байхыг зорих хэрэгтэй юм.

Монгол орны нөхцөл байдал болон Хэнтий, Төв, Хөвсгөл зэрэг тодорхой хэдэн аймагт хууль ёсны ажил хэрэг, хууль тогтоогчийн хувьд гүйцэтгэх үүргээ мэддэггүй байж болох төр засгийн албан тушаалтнуудад иргэд мэдээлэл өгч, газар ашиглалтын тал дээр гаргах шийдвэрт нөлөөлж чадах нь харагдсан билээ. Жишээлбэл, Хэнтий аймгийн Батширээт сумын ИТХ-ын төлөөлөгчид тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдлийг хянаж үзэхдээ өөрсдийн хэрэгжүүлэх ёстой эрх мэдлийн талаар мэдэхгүй байв. Тосон Заамарын засаг захиргааны албан тушаалтнууд тусгай хамгаалалттай газар нутагт тусгай зөвшөөрөл олгогдсоныг мэдээгүй байсан байна. Харин иргэдийн оролцооны ачаар энэхүү буруу үйл ажиллагааг залруулсан юм. Хэрэв та бүхэн бусдыг хонсож, бусдаас суралцаж, өөрийн байр сууриа хадгалж биш бусад хүмүүсийн ашиг сонирхлыг харгалзаж чадвал орон нутагт тань үр ашгаа өгөх “Хамтдаа ялах” аргаар асуудлыг шийдэж чадах болно.

Хавсралт 1. Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Геологи, уул уурхайн кадастрын албанаас үзүүлэх үйлчилгээний төлбөр

Үйчилгээний нэр	Уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөх төлбөр			Уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөх төлбөр /ам.доллар/
	Гадаад улсын иргэн, хуулийн этгээд /ам.доллар/	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд аж ахуйн нэгж /ам.доллар/	Монгол Улсын иргэн, хуулийн этгээд /төгрөг/	
Тусгай зөвшөөрөл шинээр авахыг хүсч гаргасан өргөдлийг хянан үзэх	1,000	400	250,000	1,000
Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай өргөдлийг хянан үзэх	2,000	2,000	1,500,000	5,000
Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийг хянан үзэх	1,000	1,000	1,000,000	2,000
Тусгай зөвшөөрлийг баталгаажуулах өргөдлийг хянан үзэх	1,500	1,500	1,000,000	2,000
Баталгаажуулах гэрээний дагуу тусгай зөвшөөрлийг шилжүүлэх өргөдлийг хянан үзэх	1,500	1,500	1,000,000	2,000
Буцаж ирсэн өргөдлийг хянаж үзэх	100	75	50,000	500
Хилийн маргааныг шийдвэрлүүлэх тухай өргөдлийг хянаж үзэх	600	350	250,000	500
Хаяж үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийг нөхөн олгох	300	200	200,000	250
Нэмэлт өргөдлийг хянаж үзэх	500	200	200,000	1,000

Тайлбар:
 1. Үйлчилгээний хөлсийг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын “Монгол шуудан” банкны төгрөгийн 1100466469, валютын 1100466470 тоот дансанд тус тус хийнэ.
 2. Хөрөнгө оруулаатын 25%-иас илүүг гадаадын аж ахуйн нэгж хийсэн бол гадаадын хөрөнгө оруулаалттай аж ахуйн нэгж гэж үзнэ.

Хавсралт 2. Байгаль орчин, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг авч болох төрийн болон төрийн бус байгууллагууд

Байгууллагын нэр	Мэдээлэл	Хаяг, холбоо барих утасны дугаар гэх мэт
Монгол улсын байгаль орчны яам	- Байгаль орчны хууль, тогтоомжуудын хэрэгжилтэй холбоотой бүх мэдээлэл - Байгаль хамгаалах талаар төрийн бодлого, стратеги - Байгалийн нөөц баялагийг хэрхэн ашиглах тухай хууль, тогтоомжийн талаарх мэдээлэл - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан - Иргэдийн нөхөрлөлийн талаар гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилт - Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх мэдээлэл - Тусгай хамгаалалттай газар нутгийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилт - Төрийн төсөв, орлого болон зарлагын талаарх мэдээлэл	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын ордон 3, Бага тойруу 44 Утас: (976-11) 312269 Факс: (976-11) 321401 http://www.mne.mn/
Улсын мэргэжлийн хяналтын газар	- Байгаль орчны болон уул уурхайн тухай хууль тогтоомж, зааварчилгааны хэрэгжилтэд хяналт тавих талаарх мэдээлэл - Уурхайн хайгуул, ашиглалт, аюулгүй байдал, химийн аюултай бодисыг гадагшлуулж хаях гэх мэт уул уурхайтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих - Байгаль орчны нөхөн сэргээлт дээр хяналт тавих - Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих - Уул уурхайн холбогдолтой төлбөр, татвар төлсөн эсэх дээр хяналт тавих	Улаанбаатар 211238, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 13, Засгийн газрын ордон 12 Утас: (976-11) 263458 Факс: (976-11) 263658 http://www.ssa.gov.mn/
Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ)	- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр, бүртгэл - Геологийн болон ашигт малтмалын нөөц баялагийн талаарх төрийн бодлого, стратеги - Уул уурхайн салбарын хөгжлийн талаарх судалгаа - Уул уурхайн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл	Барилгачдын талбай 3, Улсын төрийн өмчийн 5-р байр Улаанбаатар 211238, АМГТХЭГ-ын 1-р байр Шуудангийн салбар 38, Монголын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар Утас: (976-11) 327180, 263701 Факс: (976-11) 327180, 310370 Имэйл: mrpm@mrpm.mn http://www.mrpm.gov.mn

Байгууллагын нэр	Мэдээлэл	Хаяг, холбоо барих утасны дугаар гэх мэт
Улсын ус, цаг уурын хүрээлэн, Улсын байгаль орчны лаборатори	Агаар, ус, хөрсний чанарын хэмжүүр болон түүнд тавих хяналтын талаарх мэдээлэл, мэдээллийн сан	Улаанбаатар 210646, Чингэлтэй дүүрэг, Жуулчны гудамж 5, Улсын цаг уурын хүрээлэнгийн байр Утас: (976-11) 266592 Факс: (976-11) 326592 http://www.env.pmis.gov.mn
Газрын алба, Геодези, зураг зүйн алба	- Бүх кадастртай холбоотой мэдээлэл - Газрын нэрсийн бүртгэл болон ашиглах эрх - Газрын үнэлгээ болон төлбөр - Кадастрын судалгаа болон мэдээллийн сан - Сүйтгэгдсэн газрын нөхөн сэргээлт	Улаанбаатар 211238, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 13, Засгийн газрын ордон Утас: (976-11) 329638 Факс: (976-11) 322683 http://www.pmis.gov.mn
Олон нийтийн эрүүл мэндийн хүрээлэн	Ундны усны чанар, хөрс, агаарын бохирдол болон хоол унд, хөдөлмөрийн аюулгүй байдал гэх мэт олон нийтийн эрүүл мэндтэй холбоотой бусад зүйлс дээр хийсэн үндэсний шинжлэх ухааны судалгааны ажил	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Энхтайвны гудамж, Олон нийтийн эрүүл мэндийн хүрээлэн Утас: (976-11) 458645 http://www.phi.gov.mn
Гео-экологийн хүрээлэн	- Газар, ой мод, усны экологийн судалгаа шинжилгээ болон тэдгээрийн ашиглалт, нөхөн сэргээлт - Хүний үйл ажиллагаанаас болж газар, усанд нөлөөлж байгаа хүчин зүйл болон сөрөг нөлөөний талаар хийсэн судалгаа, шинжилгээ - Нөхөн сэргээлт, бэлчээрийн газрын менежмент, сүйдсэн бэлчээрийн газарт явуулах үйл ажиллагааны талаарх зөвлөмж - Биологийн төрөл зүйлийг хамгаалах тал дээрх судалгаа, шинжилгээ - Цаг агаарын өөрчлөлт, цөлжилт, агаарын хуурайшилтай холбоотой байгалийн болон нийгэм эдийн засгийн асуудлын талаарх судалгаа, зөвлөмж	Улаанбаатар 211238, Баянзүрх дүүрэг, Сансар хороолол, Баруун Сэлбийн гудамж 15, Гео-экологийн хүрээлэн Утас: (976-11) 325487 http://www.mas.ac.mn
Монголын уул уурхайн үндэсний ассоциаци	- Уул уурхайн аж үйлдвэртэй холбоотой мэдээлэл - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага гэх мэт төрийн бодлого, зарчимтай холбоотой болон хариуцлагатай уул уурхайг дэмжихтэй холбоотой мэдээлэл - Хариуцлагатай уул уурхай: Монголын хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт, ухагдахуун, ажлын хэсэг, олон талт оролцогчид - Монгол дахь уурхайн үйл ажиллагаанд оролцдог бусад байгууллагуудын талаарх мэдээлэл	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, Их сургуулийн гудамж 8, “Geosan” компанийн байр, 502-р өрөө Шуудангийн хаяг: Шуудангийн хайрцаг 910, Улаанбаатар 210646 Утас: (976-11) 314877, 331770 Факс: (976-11) 330032
Монгол Улсын Авиалатгай тэмцэх газар	- Авилгатай тэмцэх хөтөлбөрүүд - Авилгатай тэмцэх тухай хууль	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Сөүнийн гудамж, Үндэсний авиалатгай тэмцэх алба Утас: (976-11) 70110552, 70110252

Байгууллагын нэр	Мэдээлэл	Хаяг, холбоо барих утасны дугаар гэх мэт
Монголын байгаль орчны төрийн бус байгууллагуудын холбоо	- Байгаль орчны мэдээллийн төвөөс байгаль орчныг хамгаалах, хууль, тогтоомж, хөтөлбөр, олон улсын гэрээ, байгаль орчны үйл ажиллагаа явууладаг байгууллагуудын талаарх мэдээллийг авч болно. 1400 гаруй баримт бичиг, тайлан, ном, видео бичлэг хадгалагддаг. - Анхан болон гүнзгийрүүлсэн шатны англи хэлний дамжаа - Компьютерийн сургалт - Байгаль орчны төрийн бус байгууллагуудын менежмент, - Жижиг төслийг хэрхэн бичих - Хөдөөгийн байгаль орчны төрийн бус байгууллагуудын менежмент жижиг төсөл болон хөрөнгийн санг нэмэгдүүлэх саналууд - Байгаль орчны хуулийн төсөл - Санхүү, эдийн засгийн бодлого болон төрийн бус байгууллагын татварын хууль - Вэбсайтын дизайн - Интернет-Мэдээллийн эх сурвалж - Төрийн бус байгууллагын бизнес болон стратегийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах зэрэг үйл ажиллагаа, сургалтуудыг зохион байгуулдаг.	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Худалдааны гудамж 5, Цаг уурын хүрээлэнгийн байр, 1-р давхар, 109 тоот, Байгаль орчны мэдээллийн төв, 116-р өрөө Утас: (976-11) 315306, 318586 (976) 9911-3499 Факс: (976-11) 318586 Шуудангийн хаяг: Шуудангийн хайрцаг 192, Улаанбаатар 46 Имэйл: umengo@magicnet.mn http://www.umengo.mn
Нээлттэй нийгэм хүрээлэн	- Бодлогын талаар хийгдсэн судалгаа, дүн шинжилгээ, бодлого хууль тогтоомжийн талаарх мэдээлэл авах, олон нийтийн өргөн цар хүрээтэй мэдээллийн сан болон бодлогыг хэрхэн боловсруулах, хяналт тавих талаарх, өрөө номын сан үйлчилгээгээр хангах - Засаг захиргаа, эдийн засаг, нийгмийн бодлого, үйл явдал, хөгжилтэй холбоотой асуудлаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг явуулах	Улаанбаатар-48, Сүхбаатар дүүрэг, Жамъян гүний гудамж 5/1, “Silk Road” байр Утас: (976-11) 313207 Факс: (976-11) 324857 Имэйл: osf@forum.mn; http://www.openforum.mn
АНУ-ын Азийн сан	- Азийн сангаас Монголд хариуцлагатай уул уурхайг дэмжих зорилгоор байгалийн дархан цаазтай газар болон байгаль орчныг хамгаалах “Ирээдүйгээ баталгаажуулах нь” 3 жилийн хугацаатай хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд доорх үйл ажиллагаануудыг явуулдаг. Үүнд: - Олон талт үйл ажиллагааг дэмжих - Усны чанарын судалгаа шинжилгээг хийх - Иргэдийн нөхөрлөлийн мэдлэг чадварыг дээшлүүлэх - Байгаль орчны бодлогыг боловсруулах ажлыг дэмжих - Байгаль орчны боловсрол, олон нийтийн мэдлэгийг өргөжүүлэх	Монгол, Улаанбаатар, Нэгдсэн үндэстний гудамж 18, Шуудангийн хайрцаг 1003, Утас: (976-11) 323413, 330524 Факс: (976-11) 311497 Имэйл: general@asiafound.mn http://www.asiafoundation.org

Байгууллагын нэр	Мэдээлэл	Хаяг, холбоо барих утасны дугаар гэх мэт
“Монгол нутаг мину” эвсэл	- Уул уурхайн үйл ажиллагаа болон шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд хяналт тавих - Байгаль орчны болон уул уурхайн хуулийн хэрэгжилтэд иргэд хяналт тавих - Хариуцлагатай уул уурхайг дэмжих - Доорх 11 гишүүн хөдөлгөөний үйл ажиллагаа: - Ардын элч хөдөлгөөн (Сэлэнгэ) - Ариун Суварга хөдөлгөөн (Архангай) - Онги голын хөдөлгөөн (Өвөрхангай, Архангай, Өмнөговь) - Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн (Хөвсгөл) - Уугуул хөдөлгөөн (Өмнөговь) - Онон Улз голын хөдөлгөөн (Хэнтий, Дорнод) - Салхин Сандаг хөдөлгөөн (Говь-Алтай, Завхан) - Хонгор нутгийн дуудлага (Баянхонгор) - Ангир нүдэн Мөндөөхэй (Увс) - Тосон Заамар-Туул гол хөдөлгөөн (Төв) - Эг-Үүр эх нутаг (Хөвсгөл, Булган)	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, MONRO Imprex байр, 401-р өрөө Шуудангийн хаяг: Шуудангийн хайрцаг – 46, Улаанбаатар Утас: (976-11) 324980 Факс: (976-11) 324980 http://www.mnm-coalition.org

Хавсралт 3. Холбогдох хууль, тогтоомж

- ◆ Монгол улсын Үндсэн хууль
- ◆ Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- ◆ Байгаль орчны яамны 114-р тогтоол: Иргэдийн нөхөрлөлийн харилцаа
- ◆ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- ◆ Ашигт малтмалын тухай хууль
- ◆ Газрын тухай хууль
- ◆ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- ◆ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хууль
- ◆ Авлигын эсрэг хууль
- ◆ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль



CONSERVATION *ink*



The Asia Foundation



**Koninkrijk
der Nederlanden**

Монгол улс дахь Азийн Сангийн "Ирээдүйгээ Баталгаажуулах нь" Хөтөлбөрөөс бэлтгэв.

Нэгдсэн Үндэсний Гудамж, Ш/х 1003, Улаанбаатар хот-13; Утас: (976-11) 330-524

И-мэйл: wqmprogram@asiafound.mn

© 2007, Азийн Сан, зохиогчийн эрхээр хамгаалагдсан.

Анхны хэвлэл, Улаанбаатар хот 2007

Гэрэл зургуудийг Азийн Сан болон Консервейшн Инк/Тэд Вууд.